



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ЭРХ ЗҮЙН ТЭНХИМ

Боржигон
Мөнхсайхан МӨНХЦЭЦЭГ

КОМПАНИЙН НӨЛӨӨ БҮХИЙ ЭТГЭЭДЭД
ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГЫН ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА



Мэргэжлийн индекс
042101

Эрх Зүйн бакалаврын
зэрэг горилсон
Дипломын төсөл

Удирдсан
Ж.Хулан /LL.M/

Улаанбаатар. 2024



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ЭРХ ЗҮЙН ТЭНХИМ

Боржигон
Мөнхсайхан МӨНХЦЭЦЭГ

КОМПАНИЙН НӨЛӨӨ БҮХИЙ ЭТГЭЭДЭД
ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГЫН ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

В Мэргэжлийн индекс
D042101

Эрх Зүйн Бакалаврын Зэрэг
Горилсон Дипломын Төсөл

Удирдагч: Ж.Хулан /LL.M/

Зөвлөх: С.Нэр /зэрэгЦол/

Шүүмжлэгч: О.Нэр /ЗэрэгЦол/

ГАРЧГИЙН ТОВЬЁГ

МЭДЭГДЭЛ	i
ТАЛАРХАЛ.....	ii
ТОВЧ ХУРААНГУЙ.....	iii
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	iv
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	v
ХАВСРАЛТАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	vi
ТОВЧИЛСОН ҮГС.....	vii
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	viii
ОРШИЛ	1
Сэдэв сонгосон үндэслэл	1
Судлагдсан байдал.....	1
Сэдвийн тулгамдсан байдал	4
Судалгааны ажлын зорилго, зорилтууд	5
Судалгааны арга зүй.....	5
Судалгааны шинэлэг тал.....	5
Судалгааны ажлын онол, практикийн ач холбогдол.....	5
I БҮЛЭГ. ОНОЛЫН БҮЛЭГ	6
1.1. Сүүдрийн удирдлага буюу компанийн нөлөө бүхий этгээдийн тухай ойлголт, үүсэл хөгжил.....	6
1.1.1. Компанийн нөлөө бүхий этгээдийн тухай ойлголт	6
1.1.2. Англи улсын нөлөө бүхий этгээдийн тухай ойлголт, үүсэл хөгжил	7
1.1.3. Австрали улсын нөлөө бүхий этгээдийн тухай ойлголт, үүсэл хөгжил.....	9
1.2. Нөлөө бүхий этгээдийн тухай ойлголт Монгол улсад	10
1.4. Нөлөө бүхий этгээдийг зарим төсөөтэй ойлголтуудаас ялгах нь.	15
1.4.1. De Facto Director (Де факто удирдлага)-аас ялгах нь:.....	15
1.4.2. “Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч”-ээс ялгах нь.....	18
1.4.3. Мэргэжлийн зөвлөхүүдээс ялгах нь	19
1.5. Сүүдрийн удирдлагад тооцох шалгуур	23
II БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ХЭСЭГ	26
2.1. Нөлөө бүхий этгээдэд хариуцлага хүлээлгэх тухай эрх зүйн орчин гадаад улсад.....	26
2.1.1. Fiduciary duties буюу итгэл даах үүрэг	27
2.1.2. Англи улс дахь нөлөө бүхий этгээдийн хариуцлагын зохицуулалт.....	29
2.1.3. Австрали улс дахь нөлөө бүхий этгээдийн хариуцлагын зохицуулалт	31
2.2. Монгол улс дахь нөлөө бүхий этгээдэд хариуцлага оногдуулах тухай эрх зүйн орчин.....	32
2.2.1. Монгол улсад итгэлцлийн үүргээр сүүдрийн захиралд хариуцлага тооцох боломж.....	32
2.2.2. Компанийн тухай хуулийн 9.4.	36

2.2.3. Компанийн тухай хуульийн 84-р зүйлийн 84.10	37
2.2.4. Эрх бүхий албан тушаалтаны адилаар хариуцлага хүлээлгэх	39
2.3 Гадаад болон Монгол улсын нөлөө бүхийн этгээдийн эрх зүйн зохицуулалтын харьцуулалт	40
ДҮГНЭЛТ.....	44
САНАЛ ЗӨВЛӨМЖ.....	45
НОМ ЗҮЙ.....	46
ХАВСРАЛТ1.....	47

МЭДЭГДЭЛ

Энэхүү судалгааны ажил нь Г.Цолмонгэрэл миний бүтээл болохыг баталж байна. Мөн Санхүү Эдийн Засгийн Их сургуулийн оюуны өмч болох бөгөөд тус сургуулийн номын сан судалгааны ажлыг нийтийн хүртээл болгохыг зөвшөөрч байна.

Оюутны нэр: Мөнхсайханы Мөнхцэцэг
өдөр

Огноо: 2023 оны 1 сарын 03-ны

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд үнэтэй санал зөвлөмжөө харамгүй өгсөн удирдагч багш хууль зүйн ухааны магистр, СЭЗИС-ийн багш Ц.Даваасүрэн (LL.M), шүүмжлэгч багш Т.Наранцогт (LL.M) болон эрх зүйн тэнхимийн эрхлэгч Д.Оюун (LL.M) болон тэнхимийн бүх багш ажилчиддаа гүн талархал илэрхийлж байна.

Мөн судалгааны ажлаа гүйцэтгэхэд гүн туслалцаа, сэтгэлийн дэм, зориг өгч байсан хайртай гэр бүл, найз нөхөддөө, хамгаас хайртай охин Амирландаа талархал илэрхийлье.

ТОВЧ ХУРААНГУЙ

Энэхүү бакалаврын зэрэг горилсон судалгааны ажилдаа компанийн шийдвэр гаргалтад дам байдлаар нөлөөлөгч этгээдүүдийг тодорхойлж, хариуцлага тооцох эрх зүйн боломжийн талаар судаллаа. Монгол улсын хувьд сүүдрийн удирдлага буюу компанийн шийдвэр гаргалтад нөлөө бүхий этгээдэд хамаарах тохиолдол гардаг гэсэн таамаглалыг дэвшүүлж байгаа тул энэхүү судалгааны ажлын хүрээнд бусад улс оронтой харьцуулах байдлаар сүүдрийн удирдлагын онолыг дэлгэрүүлж, хариуцлага тооцох боломжийг судлан тодорхойлохыг зорьсон болно. Судалгааны ажлын сэдэв нь харьцангуй шинэ судлагдахуун учраас бусад улсын эх сурвалжуудыг түлхүү ашиглан, энэхүү ойлголт хамгийн түгээмэл хөндөгдөж, хуулиар зохицуулагддаг орнуудыг жишээ болгон сонгосон. Тэдгээр улсуудын жишгээр компанийн нөлөө бүхий этгээдийг хэрхэн тодорхойлж, хариуцлага тооцдог болохыг тухайн улсын Компанийн тухай хууль, шүүхийн шийдвэрүүдийн хүрээнд судалж өгөгдөл мэдээллийг цуглуулж энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэв.

Түлхүүр үгс: *Сүүдрийн удирдлага , нөлөө бүхий этгээд, нэгдмэл сонирхол бүхий этгээд, Гүйцэтгэх захирал, ТУЗ, хувьцаа эзэмшигчид, Компанийн засаглал, Компанийн эрх зүй*

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Англи, Австрали улсын нөлөө бүхий этгээдийн хуулиар зохицуулсан байдлын харьцуулалт.....	15
Хүснэгт 2. Гадаад улсын нөлөө бүхий этгээдийн тодорхойлолтын харьцуулалт.....	17
Хүснэгт 3. Мэргэжлийн зөвлөхүүдийг сүүдрийн удирдлагад тооцохгүй байх тухай Англи, Австрали улсын хуулийн зохицуулалт.....	21
Хүснэгт 4. Англи улсын компанийн хуулиар нөлөө бүхий этгээдийн хүлээх үүрэг.....	28
Хүснэгт 5. Австрали улсын компанийн хуулиар нөлөө бүхий этгээдийн хүлээх үүрэг .	30
Хүснэгт 6. Эрх бүхий албан тушаалтны хүлээх үүрэг (КтХ) болон итгэлцлийн үүргийн хамаарал.....	32
Хүснэгт 7. КтХ-ийн 9.4-р зүйл нь нөлөө бүхий этгээдийн ойлголтод хамаарах эсэх	35
Хүснэгт 8. КтХ-д заасан эрх бүхий албан тушаалтны хариуцлага.....	38
Хүснэгт 9. Англи, Австрали, Монгол улсын сүүдрийн захирлыг хуулиар тодорхойлсон байдлын харьцуулалт	39

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Английн эрх зүй дэх компанийн удирдлагын төрлүүд, тэдгээрийн тодорхойлолт... ..	11
Зураг 2. “Fiduciary duties” онол	28

ХАВСРАЛТАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хавсралт 1. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам..... 43

Хавсралт 2. Английн компанийн хууль (Companies act 2006)-д заасан нөлөө бүхий этгээдийн хүлээх үүрэг: 51

Хавсралт 3. Австралийн компанийн хууль (Corporations act 2001)-д заасан нөлөө бүхий этгээдийн хүлээх үүрэг 54

ТОВЧИЛСОН ҮГС

Нэршил

Тайлбар

de jure

албан ёсоор бүрэн хэмжээгээр хүлээн зөвшөөрөх, “хууль ёсны” гэсэн утгатай латин үг. Олон улсын эрх зүй дэх улс орны тусгаар тогтнолыг “бүрэн” хүлээн зөвшөөрөх хэлбэр бөгөөд төрийн тэргүүний хувьд “бүрэн эрх бүхий удирдагч” гэсэн утгаар хэрэглэнэ.

de facto

сүүдрийн удирдлага, компанийн удирдлагад хамаарахгүй боловч заавар, чиглэмж өгөх байдлаар нөлөөлж заншсан этгээд

shadow director

итгэл даах үүргийн онол (зарим улсад хуульчилж өгсөн байдаг. Жишээлбэл, АНУ, Их Британи, Австрали, Канад)

fiduciary duties

Англи улсад одоогийн байдлаар мөрдөгдөж буй Компанийн тухай хууль

Companies Act 2006

Австрали улсад одоогийн байдлаар мөрдөгдөж буй Компанийн тухай хууль

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Товчлол	Тайлбар
ТӨК	Төрийн өмчит компани
КтХ	Компанийн тухай хууль
ГУ	Гүйцэтгэх удирдлага
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
МУ	Монгол улс
УИД	Улсын их дэлгүүр
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо

ОРШИЛ

Сэдэв сонгосон үндэслэл

Компани нь хуулийн этгээд болохынхоо хувьд хиймэл, хуулиар бий болгосон, биегүй этгээд юм. Иймээс компани ямар нэг үйлдлийг хийхдээ зөвхөн өөрийн төлөөлөгчөөр дамжуулж тэрхүү үйлдлээ илэрхийлдэг. Компанийг төлөөлж шийдвэр гаргах эрх бүхий этгээд нь гүйцэтгэх удирдлага байна. Иймд компанийн удирдлага бүхий этгээдүүдийн компанийг төлөөлж хийсэн үйлдэлд хөндлөнгөөс нөлөөлөгч “сүүдрийн удирдлага”-ын тухай сэдвийг хөндөж байна.

Зах зээлийн эдийн засгийн харилцааг зохицуулах хууль тогтоомж, түүний дотор Компанийн тухай хууль батлагдсанаар манай улсад компанийн бүтэц, зохион байгуулалтад тулгуурласан бизнесийн үйл ажиллагаа ихээхэн өргөжиж байгаа нь сайшаалтай боловч зарим нэг асуудлыг зохицуулах шаардлагатай болж байна. Тодруулбал, хөндлөнгийн этгээд өөрийн эрх мэдлийг ашиглан тухайн компанийн шийдвэрт нөлөөлсөн тохиолдолд үүнийг эрх зүйн хүрээнд хэрхэн тодорхойлж, зохицуулах тал дээр хуримтлуулсан туршлага хомс билээ. Иймд тухайн асуудалд эрх зүйн зохицуулалт болон компанийн өөрийн засаглалын зохицуулалт хангалтгүй байгаагаас компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үүрэг, хариуцлага сул байх зэргээр компанийн засаглалын горим алдагдаж, түүнээс үүдсэн шийдвэрийн улмаас хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талуудын эрх ашиг хохирох нь цөөнгүй байна.

Дэлхий дахинаа компанийн бүтэц зохион байгуулалт дан ганц эрх зүйн зохицуулалтаас хэдийнээ хальж өдрөөс өдөрт улам нарийсан өөрийн гэсэн нийтлэг зарчим, жишиг стандарттай болоод байгаа билээ. Тэгвэл бусад улс оронд компанийн шийдвэр гаргалтад нөлөөлөгч “сүүдрийн удирдлага”-ыг хэрхэн тодорхойлж, эрх зүйн хүрээндээ хэрхэн тусгаж зохицуулдаг тухай Монгол улстай харьцуулж судлах хэрэгцээ ийнхүү үүсэж байгаа болно.

Судлагдсан байдал

Монгол улсын хувьд:

Монгол улсад Компанийн удирдлагын шийдвэр гаргалт, компанийн засаглал, компанийн удирдлагыг хэрэгжүүлэх эрх бүхий этгээдүүдийн эрх зүйн байдал, эрх үүргийн талаарх сэдвүүдийг судалсан судалгаа түгээмэл байдаг. Харин компанийн

сүүдрийн удирдлага буюу шийдвэр гаргалтад хөндлөнгөөс нөлөөлөгч нөлөө бүхий этгээдүүдийг тодорхойлсон, тэдгээрийн эрх зүйн байдал, хариуцлага хүлээлгэх тухай судалсан судалгаа одоогийн байдлаар байхгүй. Хэдийгээр тийм боловч зарим судлаачид Компанийн нөлөө бүхий этгээдэд хамаарах онолын ойлголтуудыг судалгаа, нийтлэлдээ хэрэглэж эхэлсэн байгаа явдал нь энэхүү сэдэв нь судлагдаж эхлэх хандлагатай байгаа гэж үзэж болохоор байна.

Монголын Нээлттэй Нийгэм Форумас эрхлэн гаргадаг Бодлогын шинжилгээний 36 дугаар тайланд “Нөлөө бүхий этгээдэд хүлээлгэх хариуцлага” хэсэгт Монгол Улсын ТӨК-ийн ТУЗ-ийн шийдвэрт хөндлөнгөөс нөлөөлж буй этгээдүүдийг төрийн байгууллага, албан тушаалтан байж болох тухай дурдсан бөгөөд тэдгээр нь удирдамж, чиглэл өгөх, ашиг сонирхлын зөрчил бүхий шийдвэр гаргахыг тулгах зэргээр нөлөөлөх явдал түгээмэл гардаг тухай бичсэн байна. Түүнчлэн “shadow director”, де факто удирдлага буюу “de facto organs” нэр томъёог ашиглан нөлөө бүхий этгээд бий болох нөхцөл, шалгуурыг судлан оруулсан байна.¹

Судлаач Г. Даваанямын “Компанийн эрх зүйн онол, практик” бүтээлд Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн “Дотоод харилцаа” бүлэгт “де факто” удирдлагыг судалсан байх бөгөөд бодит байдал дээрх гүйцэтгэх удирдлагын ойлголтыг тодорхойлж бичсэн байна.

Мөн 2022 онд Г.Давааням ахлагчтай судалгааны баг “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн төлөөлөн удирдах зөвлөл, Олон улсын туршлага ба Монгол улс, Уул уурхайн салбарын жишээн дээр” судалгааг бичиж нийтийн хүртээл болгосон. Энэхүү судалгааны ажлаар ТӨК-ийн ТУЗ-тай холбоотой онолын асуудлууд, олон улсын чиг хандлагыг судалсан байх бөгөөд Монгол улс дахь ТӨК-ийн өнөөгийн байдлын тухай судалсан байдаг. Тодруулбал, ТӨК-ийн удирдлагад төрөөс төлөөлөх эрх бүхий этгээдийн төлөөллийг хэрэгжүүлэх эрхийн хүрээг тодорхойлж, бусад улсуудад хэрхэн зохицуулдаг тухай судалгааны 92-р хуудаснаас илүү тодорхой байдлаар дурдагджээ. Ийнхүү судлагдсан байгаа байдал нь сүүдрийн удирдлагын Монгол улсад илэрч буй нэгэн нөхцөлд тооцогдож байгаа талаас судлахад ач холбогдолтой бүтээл юм.

Эрх бүхий этгээдэд хүлээлгэх хариуцлагын хувьд “fiduciary duty” буюу итгэлцлийн үүрэг яригддаг. Энэ сэдвээр хэд хэдэн судалгааны ажлууд хийгдсэн байгаа нь мөн сүүдрийн удирдлагын сэдэвтэй хамаарал бүхий судлагдахуун болж байгаа юм. Жишээлбэл, 2024 онд Э.Цэлмэг судлаачийн “Determination of fiduciary duties in the

¹ Түвшинжаргал М.; Бодьбилиг.А; 2023; Төрийн өмчит компанийн ТУЗ-ийн бүрэн эрх ба хариуцлага,Нээлттэй нийгэм форум, Улаанбаатар

context of director liability in Mongolia” нийтлэл нь итгэлцлийн үүрэг болон бизнесийн шийдвэрийн зарчим (business judgment rule) нь Монголын компанийн тухай хуульд тусгагдсан эсэхийг судлахыг зорьсон байна. Судалгааны ажлын 12-р хуудаснаас Компанийн тухай хуулийн 84-р зүйлийг итгэлцлийн үүрэгтэй харьцуулсан байдлаар судалсан байгаа нь сүүдрийн удирдлагад хүлээлгэх хариуцлагын хэсгийг судлахад ач холбогдол бүхий байна.

Компанийн нөлөө бүхий этгээд буюу сүүдрийн удирдлагын тухай нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлага хараахан гараагүй байгаа бөгөөд Монголын эрх зүйн тогтолцоонд сүүдрийн удирдлагыг хэрхэн тодорхойлсон нь тодорхойгүй байгаа тул онолын үзэл баримтлал, бусад орнуудын туршлагыг Монгол улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулан судлах шаардлагатай хэрэгцээ байна.

Гадаад улсын хувьд:

Сүүдрийн удирдлага хэмээх ойлголт нь гадаад улс орны компанийн тухай хуулиудаар ихэвчлэн зохицуулагдсан байдаг. Жишээлбэл, Англи улсын хувьд 2006 оны компанийн хуулиар сүүдрийн удирдлагыг тодорхойлж, түүнийг албан ёсоор томилогдсон захирлын нэгэн адилаар хариуцлага хүлээлгэх тухай заасан байдаг.² Жишээлбэл:

Энэтхэг: 2013 оны Компанийн тухай хууль нь Их Британийн тодорхойлолттой адил сүүдрийн захирал гэсэн ойлголтыг хүлээн зөвшөөрч, тухайн хүний компанийн захирлуудад үзүүлэх нөлөөнд анхаарлаа хандуулдаг.

Австрали: 2001 оны Корпорацын тухай хууль нь компанийн удирдлагад сүүдрийн удирдлагын ойлголтыг багтаасан бөгөөд тэднийг албан ёсоор томилогдоогүй боловч удирдамжийг нь удирдах зөвлөл дагаж мөрддөг хувь хүмүүс гэж үздэг.

Сингапур: Компанийн тухай хуульд сүүдрийн захирлуудтай холбоотой заалтуудыг Их Британи, Австралийн адил тодорхойлсон байдаг.

Өмнөд Африк: 2008 оны Компанийн тухай хууль нь ТУЗ-ийн шийдвэрт нөлөөлж болохуйц сүүдэр захирлуудын тухай ойлголтыг хүлээн зөвшөөрдөг.

² Corporations Act 2001. Section 9AC(1)(b)(i), Companies act 2006. s.250

Шинэ Зеланд: 1993 оны Компанийн тухай хууль нь албан ёсоор захирал биш ч хяналтаа хэрэгжүүлдэг хүмүүст чиглэсэн үзэл баримтлалыг тусгасан.

Энэхүү сэдвийн хүрээнд гадаад улс орны бүтээлүүдээс дурдвал, судлаач Риханна Касимын “A Comparative Analysis of the Identification of De Facto and Shadow Directors in South Africa, the United Kingdom and Australia” 2021 оны судалгааны ажилдаа Өмнөд Африк, Англи, Австрали улсуудын нөлөө бүхий этгээдийн эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалсан байх бөгөөд тухайн бүтээлд Өмнөд Африкийн компанийн тухай хуулийн зохицуулалт нь ямар асуудал, дутагдалтай байгааг Англи, Австрали улсын жишгээр тодорхойлж, дүгнэлт, санал зөвлөмжийг гаргасан байна.

Түүнчлэн Кентийн их сургуулийн судлаач Коолин Р Моорэ-ийн “Obligations in the shade: the application of fiduciary directors’ duties to shadow directors” судалгааны ажилдаа итгэлцлийн үүргийн дагуу сүүдрийн удирдлага нь компанийн албан ёсны удирдлагын нэгэн адил хариуцлагыг хүлээх тухай судалгааг хийсэн байдаг.³ Судалгаанд сүүдрийн удирдлага нь албан ёсны захирлын үүрэггүй ч, хэрхэн компанийн шийдвэр гаргалтад нөлөөлдөг талаар, мөн тэр тохиолдолд үүрэг хариуцлага хүлээх ёстой тухай онцолжээ. Түүнчлэн судалгаанд сүүдрийн захирлуудыг итгэлцлийн үүргийг хүлээх нь зөв эсэх асуудал дээр хэд хэдэн шалгуурыг авч үзсэн байдаг. Эдгээр шалгуур нь сүүдрийн захирлуудын хуулийн үүрэг хариуцлагыг тодорхойлоход чухал үүрэгтэй бөгөөд судалгаанд хэлсэнчлэн асуудлыг шийдэхэд илүү тодорхой логик үндэслэлтэй байлгахыг зорьсон байна.

Сэдвийн тулгамдсан байдал

Компанийн удирдлагын шийдвэр гаргалтанд сүүдрийн удирдлагын зүгээс ямар нэг нөлөө үзүүлсэн байх тохиолдолд түүнээс гарах үр дагавар, учирсан хохирлыг хэрхэн барагдуулж байгаа нь ойлгомжгүй байгаа бөгөөд, шүүх Компанийн тухай хуулийн “эрх бүхий албан тушаалтан”-д хариуцлага хүлээлгэхтэй төсөөтэй байдлаар шийдвэрлэж байгаа билээ. Ийнхүү нөлөө бүхий этгээдийн хариуцлагын талаарх эрх зүйн байдал, зохицуулалттай холбоотой асуудлыг илрүүлэх, засаж сайжруулах нь зүйтэй болоод байна. Зөвхөн компанийн эрх зүй эрт үүсэж хөгжсөн орнуудаас гадна Энэтхэг, Ирланд, Шинэ Зеланд, Өмнөд Африк зэрэг бусад улс орнуудад нөлөө бүхий этгээдийн ойлголтийг хууль эрх зүйн орчиндоо аль хэдийн нэвтрүүлж, зохицуулж эхэлсэн байна.

³ Obligations in the Shade: The Application of Fiduciary Directors' Duties to Shadow Directors at SLS Conference 2014, Nottingham (Academia.edu, 2014),

Судалгааны ажлын зорилго, зорилтууд

Компанийн удирдлагын шийдвэр гаргалтад нөлөө бүхий этгээдийн оролцоо, нөлөөлөл байсан тохиолдолд үр дагавраас үүсэх хариуцлагыг хэн хүлээх, хариуцлага хүлээлгэх зохицуулалтанд Монгол улсын Компанийн тухай хуульд тулгамдаж буй зарим асуудал, дутагдлыг нээн илрүүлэх хохирлыг барагдуулах боломжтой эсэх, яаж шийдвэрлэж болох талаар, мөн бусад улс оронд тухайн асуудлыг эрх зүйн хүрээндээ хэрхэн зохицуулдаг болохыг онолын талаас судалж энэхүү судалгааны ажлын хүрээнд санал, дүгнэлт боловсруулахад судалгааны ажлын маань зорилго оршино.

Судалгааны арга зүй

Онолын судалгааг хууль эрх зүйн баримт бичиг, сурах бичиг, судлаачдын бичсэн судалгааны ажлууд, цахим эх сурвалжуудыг ашиглан гүйцэтгэсэн. Энэхүү судалгааны ажилд компанийн удирдлагатай холбоотой хууль, дүрэм журам, холбогдох онол, практикийн хоорондох уялдаа холбоо, эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд гарч буй асуудлыг танин мэдэхийн тулд харьцуулалтын арга, түүвэрчлэлийн арга, логикийн, дүн шинжилгээ хийх аргыг ашиглах болно.

Судалгааны шинэлэг тал

Компанийн эрх зүйн тухай, тэр дундаа Компанийн засаглалын тухай асуудлуудаарх судалгаа, эрдмийн ажил зэрэг эх сурвалжууд олон байдаг хэдий ч сүүдрийн удирдлага, далд удирдлагын нөлөөллийн тухай онолын судалгаа одоогийн байдлаар хангалттай хэмжээнд хөндөгдөж судлагдаагүй байна. Гэвч компанийн удирдлагын шийдвэрт далд байдлаар нөлөө үзүүлэх, дам байдлаар албан ёсоор томилогдсон удирдлагаас гадна өөр этгээд шийдвэр гаргах тохиолдол нь Монгол улсад аль хэдийн байдаг асуудал мөн учраас энэ тухай дүн шинжилгээг хийж харьцуулан судалснаараа шинэлэг байна.

Судалгааны ажлын онол, практикийн ач холбогдол

Сүүдрийн удирдлагын ойлголтыг онолын хүрээнд ямар шалгуураар үүсдэг тухай, мөн ямар шалгуураар компанийн шийдвэрт нөлөөлөхүйц далд нөлөөллийг үзүүлсэн гэж тооцох тухай тодорхойлж, тэрхүү үйлдэлд нь хэрхэн хариуцлага тооцох тухай бусад орны жишээн дээр харьцуулж санал, дүгнэлтийг боловсруулахад энэхүү судалгааны ач холбогдол оршино.

I БҮЛЭГ. ОНОЛЫН БҮЛЭГ

1.1. Сүүдрийн удирдлага буюу компанийн нөлөө бүхий этгээдийн тухай ойлголт, үүсэл хөгжил

1.1.1. Компанийн нөлөө бүхий этгээдийн тухай ойлголт

Сүүдрийн удирдлагын тодорхойлолт, эрх үйн зохицуулалтыг авч үзэхээс өмнө “компани” хэмээх ойлголттой хэрхэн уялдаж байгаа талаар товчхон авч үзье. Монгол улсын хувьд нэг улс төрийн дэглэмээс нөгөө улс төрийн дэглэм рүү шилжсэн үе буюу 1990 оноос “компани” хэмээх нэр томъёог бүрэн утгаар нь хэрэглэж эхэлжээ⁴. Компани нь ашиг олох зорилгоор үйлчилгээ борлуулдаг хуулийн этгээд мөн бөгөөд тухайн компанийн хувьцааг худалдан авах байдлаар компанид хөрөнгө оруулсан тохиолдолд хувьцаа эзэмшигч болдог. Нэг үгээр хэлбэл компанид хөрөнгө оруулсан хэмжээгээр тухайн компанийн өмчлөгч болдог учраас хувьцаа эзэмшигчийн эрхийг хамгаалах, компанийн ашигтай ажиллагааг хангах шаардлагатай болдог. Ийнхүү компанийн ашигтай ажиллах эсэх компанийн засаглалтай шууд холбоотой болж байна.⁵ Хувьцаа эзэмшигч нь компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцож чаддаггүй учраас хяналтын үйл ажиллагааг тусдаа этгээд буюу ТУЗ-ыг томилж гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хянаж байдаг. Харин ТУЗ-ын зүгээс ажил, үүргээ зүй зохистойгоор биелүүлж, хяналт хийх ба дүгнэлтээ хувьцаа эзэмшигч нарт мэдээлэх үүрэгтэй байдаг. Гэтэл зарим тохиолдолд ТУЗ, гүйцэтгэх удирдлагад хамаарахгүй боловч компанийн шийдвэр гаргалтын явцад шууд ба шууд бус байдлаар нөлөөлж компанийн ашиг сонирхолд харшлах үр дагавар гарсан тохиолдолд хэнд хариуцлага хүлээлгэх тухай асуудал үүсч байна. Товчхондоо, компанийг албан ёсоор удирдах эрхгүй этгээд боловч удирдлагын түвшний шийдвэр гаргалтанд нөлөөлж буй тохиолдолд энийг сүүдрийн удирдлага гэж үзнэ.

Компанийн нөлөө бүхий этгээд буюу “shadow director” нь компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор компанийн удирдлагад зааварчилгаа өгөх байдлаар нөлөөлж заншсан этгээдийг хэлнэ.⁶ Английн эрх зүйд үүнийг далд удирдлага, сүүдрийн удирдлага буюу “shadow director”, де факто удирдлага гэж нэрлэдэг. Түүнчлэн тэднийг “сүүдэрт нуугдаж буй дүрүүд”, “хүүхэлдэйн мастерууд” эсвэл “муурын савар” гэж

⁴ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Компанийн эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, 2020

⁵ Амарсанаа Б., Компанийн засаглал, компанийн эрх зүйн тулгамдсан асуудал, 2012

⁶ UK, Companies Act 2006, 251-р зүйл

тодорхойлсон тохиолдлууд ч бий.⁷ Өөрөөр хэлбэл компанийн удирдлагын албан ёсны бүтцэд хамаарахгүй боловч өөрийн эрх мэдэл, нөлөөллөө ашиглан компанийн шийдвэрт нөлөөлөх боломжтой этгээд мөн.⁸

1.1.2. Англи улсын нөлөө бүхий этгээдийн тухай ойлголт, үүсэл хөгжил

Англи улс нь сүүдрийн удирдлагын тухай ойлголтыг хамгийн эрт зохицуулж эхэлсэн түүхтэй улс гэдэг утгаараа бусад улс орнуудтай харьцуулахад илүү тодорхой байдлаар зохицуулсан байдаг. Английн эрх зүйд компанийн удирдлагын гурван үндсэн ангиллыг хүлээн зөвшөөрдөг:

1. де юре удирдлага
2. де факто удирдлага
3. “shadow director” буюу сүүдрийн удирдлага⁹.

Зураг 1. Английн эрх зүй дэх компанийн удирдлагын төрлүүд, тэдгээрийн тодорхойлолт



Эх сурвалж: *Obligations in the Shade: The Application of Fiduciary Directors' Duties to Shadow*, University of Kent, 2016

Англи улсын Companies Act 2006-ын 251-р хэсэгт “Тухайн хүн нь албан ёсны захирал биш боловч компанийн захирлуудад заавар, зөвлөмж өгдөг ба тэд үүнийг нь дагаж, компанийн үйл ажиллагааг удирддаг бол тухайн хүнийг сүүдрийн захирал гэж үзнэ” хэмээн заасан байдаг.

1980 онд хэрэгжиж эхэлсэн Английн Компанийн тухай хуулийн 63-р зүйлд энэхүү нэр томьёо нь хамгийн анх хэрэглэж, хуулиар зохицуулж байсан.¹⁰ Өдгөө нэр томьёоны

⁷Shadow Director: Who Are They and What Are Their Duty? (2024), <https://fareezlaw.com/company/shadow-director-who-are-they-and-what-are-their-duty/>.

⁸ Түвшинжаргал М.; Бодьбилиг.А; 2023; Төрийн өмчит компанийн ТУЗ-ийн бүрэн эрх ба хариуцлага,Нээлттэй нийгэм форум, Улаанбаатар

⁹ John Doe, *Obligations in the Shade: The Application of Fiduciary Directors' Duties to Shadow* (University of Kent, 2016)

¹⁰John Doe, *Shadow Director* (2014), x3

тодорхойлолт нь төдийлөн өөрчлөгдөөгүй бөгөөд одоо хэрэгдэж буй 2006 оны Английн компанийн тухай хуульд нөлөө бүхий этгээдэд хүлээлгэх хариуцлагын тухай илүү нарийвчлан шинэчилсэн байдалтай байна.

Хамгийн анх 1980 оны Английн компанийн тухай хуульд сүүдрийн удирдлагыг тодорхойлохдоо “компанийн удирдлагын шийдвэр гаргалтад заавар, зөвлөмж өгөх байдлаар нөлөөлөгч хүн” гэж заасан байдаг. Иймд Английн шүүх 1990 онд нэгэн кейсээр хувь хүн эсвэл байгууллагыг ямар шалгуураар сүүдрийн удирдлага буюу далд нөлөө бүхий этгээд гэж үзэхийг тодорхой болгож өгсөн. Тодруулбал, Кувейтийн Азийн банк болон “National Mutual Life Nominees” ХХК-ийн энэхүү кейс дээр Кувейт Азийн Банк нь тухайн компанид зээл олгож байсан бөгөөд сүүдрийн захирлууд (Кувейт Азийн Банкны албан тушаалтнууд) компаниас санхүүгийн шийдвэрүүдийг гаргахдаа зохимжгүй, буруу чиглэл өгснөөр зээлдэгч компанийн санхүүгийн байдал хүндэрч тухайн компани хохирсон байна. Хэргийн гол асуудал нь сүүдрийн удирдлагыг хэрхэн тодорхойлж байгаа тухай байсан бөгөөд тухайн хүн албан ёсны захирлын байр суурь эзэлдэггүй ч компанийн захирлуудын шийдвэрт нөлөө үзүүлж байсан бол түүнийг сүүрийн удирдлага гэж үзэх ёстой юу гэсэн асуудал байсан. Шүүхийн шийдврээр сүүдрийн захирал гэж албан ёсны захирлын албан тушаалгүй, гэхдээ компаний удирдлагад нөлөө үзүүлж, түүний шийдвэр гаргалтад чиглэл өгдөг хүн байж болно хэмээн тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл, сүүдэр захирлууд нь компаниудын албан ёсны захирлуудад заавар, зөвлөгөө өгөх замаар тэдний үйл ажиллагааг удирддаг хүмүүс юм.

2006 оны Английн компанийн хуульд **Companies Act 2006** (2006 оны Компанийн тухай хууль)-ийн **251-р хэсэгт** "сүүдрийн захирал" (shadow director) гэсэн ойлголтыг албан ёсоор тодорхойлсон байдаг. Тухайн хүн нь албан ёсны захирал биш боловч компанийн захирлуудад заавар, зөвлөмж өгдөг ба тэд үүнийг нь дагаж, компанийн үйл ажиллагааг удирддаг бол тухайн хүнийг "сүүдрийн захирал" гэж үзнэ хэмээн заасан байдаг.

Иймээс хамгийн анхны тодорхойлолтыг одоогийнхтой харьцуулбал сүүдрийн удирдлагын тухай ойлголт өөрчлөгдөөгүй боловч доорхи байдлаар ялгаатай болжээ.

1. **1986 оны Insolvency Act:** Энэ хуульд сүүдрийн захирлыг албан ёсны захирал биш боловч компанийн захирлуудад заавар, зөвлөмж өгдөг, захирлууд түүний зааврыг дагаж шийдвэр гаргадаг хүн гэж тодорхойлсон. Энэ хууль нь голчлон компанийн төлбөрийн чадваргүй болсон нөхцөлд хэрэгжих үйл ажиллагааг зохицуулдаг тул сүүдрийн захирлыг компанийн санхүүгийн хүндрэл үүссэн тохиолдолд хариуцлагад татахад чиглэгдсэн.

2. **2006 оны Companies Act:** 251-р хэсэгт мөн сүүдрийн захирлын тухай заасан бөгөөд энэ хуулинд илүү өргөн хүрээтэй тодорхойлолттой болсон. 2006 оны хуульд сүүдрийн захирлыг зөвхөн төлбөрийн чадваргүй нөхцөлд бус, компанийн бүхий л үйл ажиллагааны явцад албан ёсны бус боловч удирдлагад нөлөөлж буй хүнээр ойлгох болсон.

Товчхондоо, **1986 оны хууль** нь сүүдрийн захирлыг санхүүгийн хүндрэлтэй холбогдуулан хязгаарлагдмал хүрээнд авч үздэг байсан бол **2006 оны хууль** нь түүнийг компанийн бүх үйл ажиллагаанд хамааруулж, илүү өргөн хүрээтэй тодорхойлсон. Одоогийн байдлаар 2006 оны Companies act нь одоог хүртэл мөрдөгдсөөр байгаа.

1.1.3. Австрали улсын нөлөө бүхий этгээдийн тухай ойлголт, үүсэл хөгжил

1900 оны эхээр компаниудын хууль эрх зүйн бүтэц хөгжиж байсан ч, сүүдрийн удирдлагын талаар тодорхой хууль эрх зүйн зохицуулалт байгаагүй. Албан ёсоор захирлын албанд томилогдоогүй хүмүүс компанийг далд байдлаар удирдаж, нөлөөлж байгаа тохиолдлууд шүүхэд илэрснээр сүүдрийн удирдлагын тухай ойлголт нь Австрали улсад анх үүссэн. Австралийн корпорацийн хуулийн 2001 оны шинэчлэл нь сүүдэр захирлыг нэршлээр нь биш боловч ерөнхий утгаар нь “компанийн удирдлагад оролцдог боловч албан ёсоор томилогдоогүй хүмүүс” гэж тодорхойлсон байдаг. Энэхүү хуулиар компанийн удирдлагын бүтэц, үүрэг хариуцлагыг тодорхойлсон бөгөөд компанийн бодлого, үйл ажиллагаанд нөлөөлдөг хүмүүсийг хуулиар тодорхойлж, тэдний хариуцлагыг мөн зохицуулж өгсөнөөрөө сүүдрийн захирлын үүргийг ялгаж салгахад илүү ач холбогдолтой болжээ.

Австрали улсын тухайд сүүдрийн удирдлагыг Англи улстай харьцуулахад ялгаатай байдлаар хуулиндаа тайлбарлаж тусгасан. Австрали улсын компанийн хуулинд зөвхөн сүүдрийн удирдлагыг яг нэршлээр нь тайлбарлаагүй боловч “удирдлага” гэсэн ерөнхий нэршлийг тайлбарласан байдаг бөгөөд удирдлагад хамаарах нөхцөлүүдийг тоочиж бичсэн байдаг. Corporations Act-ын 9-р хэсэгт “удирдлага”-ыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

(a) Хэрэв хүн:

- (i) Захирлын албан тушаалд томилогдсон бол, эсвэл
- (ii) албан тушаалын нэр нь ямар байх нь хамаагүй орлогч захиралтай адил албан тушаалд томилогдсон бөгөөд тухайн үүргийг гүйцэтгэж байгаа бол,

(b) Харин, эсрэгээр нь заагаагүй бол, хуулийн дагуу захирлаар томилогдоогүй хүн, хэрэв:

- (i) Тухайн хүн захирлын үүргийг гүйцэтгэж байгаа бол, эсвэл
- (ii) Компаний захирлууд тухайн хүний заавар, хүсэлтийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа бол.

Corporations Act-ын 9-р хэсгийн 9.b.ii-т “компанийн захирал биш боловч компанийн удирдлагууд түүний заавар, хүсэлтийн дагуу үйл ажиллагаа явуулж заншсан хүнийг удирдлагад тооцно” гэж заасан байгаа нь сүүдрийн удирдлагын тодорхойлолтод илт нийцэж байна. Түүнчлэн Австралийн дунд шатны шүүх сүүдрийн удирдлагыг “хууль ёсны дагуу удирдлагын эрх мэдэл анхнаасаа байгаагүй, эсвэл байхаа болисон боловч захирлын албыг хэрэгжүүлж буй этгээд” гэж тодорхойлсон байдаг.

Хуульд заасан байдлаас нь харвал Англи улсын тодорхойлолтын дагуу захирлууд зөвхөн удирдлагад хамаарахгүй этгээдээс зөвлөмж авах нь хангалттай биш, тэд зааварчилгаа эсвэл удирдамжын дагуу “үйл ажиллагаа явуулах” ёстой. Мөн тэд үүнийг зөвхөн нэг удаа, эсвэл заримдаа хийдэг нь хангалттай биш, удирдлагууд эдгээр зааварчилгаа, удирдамжийн дагуу үйл ажиллагаа явуулахад "сурсан, дассан" байх ёстой гэж нарийвчилж заасан байгаа нь Австрали улстай харьцуулахад илүү дэлгэрэнгүй тодорхойлжээ.

1.2. Нөлөө бүхий этгээдийн тухай ойлголт Монгол улсад

Монгол улсын хувьд “сүүдрийн удирдлага” хэмээх нэр томъёо нь хараахан хэрэглэгдэж эхлээгүй байгаа ч онолын тодорхойлолтууд, Англи, Австрали улсын КтХ-д хэрхэн тодорхойлсон байгааг үндэслэн дараах байдлаар үүсч болохоор байна.

Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьд:

Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьд гүйцэтгэх удирдлага нь компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд байдаг. Эзэмшил болон удирдлага салаагүй хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх удирдлага нь компанийн том хувьцаа эзэмшигч байх эсвэл түүнээс авсан шийдвэрийн үндсэн дээр шийдвэрийг гаргадаг хувь этгээд байх нь нийтлэг юм.

Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн бизнесийн практикт 1) том хувьцаа эзэмшигч өөрөө гүйцэтгэх удирдлага биш боловч, компанийг төлөөлөн гэрээ хэлцэл хийсэн, эсхүл 2) улсын бүртгэл дээр тодорхой этгээдийг гүйцэтгэх удирдлагаар бүртгүүлсэн боловч, бодит байдал дээр аль нэг хувьцаа эзэмшигч компанийг удирдаж байх тохиолдол түгээмэл байдаг.

Энэ тохиолдолд хууль хэрэглээний хүрээнд бодит байдал дээр гүйцэтгэх удирдлагын ойлголт буюу “**shadow director**”, “**de facto director**” яригдахыг анхаарах шаардлагатай. Компанийн тухай хуульд бодит байдал дээрх гүйцэтгэх удирдлагын

талаар зохицуулаагүй боловч, гүйцэтгэх удирдлага гэдэг нь компанийн гэрчилгээ болоод хуулийн этгээдийн улсын бүртгэл дээр хэний нэр бүртгэлтэй байгаагаас үл хамааран компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг үүргийг гүйцэтгэж буй этгээдийг хэлдэг.

ТӨК-ийн хувьд төлөөлөгчөөр дамжуулан сүүдрийн удирдлагыг хэрэгжүүлэх нь:

ТӨК нь компани гэдэг утгаараа өөрийн гэсэн стратеги, удирдлагатай байх ёстой. Компанийг бодлого, стратегиар хангах, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих субъект нь компанийн удирдлага буюу ТУЗ байна. Харин төрөөс ТӨК-ийн үйл ажиллагаанд оролцоходоо төлөөлөгчөөрөө дамжуулж, хувьцаа эзэмшигчийн журмаар оролцдог. Энэ тохиолдолд төр нь ТӨК-ийн нийт гаргасан энгийн хувьцааны 100 хувийг төр эзэмшдэг, эсвэл нийт гаргасан энгийн хувьцааны 34-өөс 100 хүртэл хувийг нь төр эзэмшдэг байхаар журамд¹¹ заасан байдаг. Төрийн өмчит компанийн хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг тухайн компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд томилогдсон төрийн өмчийн төлөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлнэ. Ийнхүү хэрэгжүүлэхдээ удирдамж, заавар өгөх байдлаар¹² удирдлагын шийдвэр гаргалтанд оролцдог гэсэн үг. Энэхүү оролцож байгаа байдал нь “сүүдрийн удирдлага”-ын заавар, зөвлөмж өгөх байдлаар “нөлөөлж заншсан байх” гэсэн шинжийг агуулж байгаа юм. Үүнээс харвал төр нь удирдамж, заавар өгөх байдлаар ТӨК-д сүүдрийн удирдлагыг хэрэгжүүлэх боломжтой байна гэж үзэж болохоор байна.

ТӨК-ийн ТУЗ-д төрийг төлөөлөн хувьцаа эзэмшигчийн эрх хэрэгжүүлэхээр томилогдсон төлөөлөгч нь бизнес, санхүүгийн мэдлэг туршлагын хувьд дутмаг бөгөөд эрх баригч намын удирдлага, улс төрийн лидер, эрх бүхий албан тушаалтны хамаарал бүхий этгээд байх нь элбэг. Ийм байдлаар томилогдсон төлөөлөгч ТУЗ-ийн гишүүний чиг үүргийг (эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, аудит, гүйцэтгэх удирдлагын хяналт, стратеги бодлого тодорхойлолт гэх мэт) үр дүнтэй хэрэгжүүлэх чадамж сул байдаг. Өөрөөр хэлбэл, ТУЗ-ийн гишүүний мэргэшсэн байх шалгуурыг хангаж чаддаггүй.

Англи улс: Их Британид төрийн өмчит компаниуд нь Companies Act 2006 болон төрийн удирдлагын байгууллагуудын хууль тогтоомжийн дагуу удирдлагын албан ёсны захирлуудыг сонгон шалгаруулдаг. Companies Act 2006 хуульд заасан захирлуудын сонгон шалгаруулалт нь 154-р зүйл болон 168-р зүйл-д зааснаар зохион байгуулагддаг. Их Британи улсад Бизнес, эрчим хүчний болон аж үйлдвэрийн стратегийн яам (BEIS) төрийн өмчит компаниудыг хянаж байдаг. Үүний нэг жишээ нь Royal Mail эсвэл Network

¹¹ Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам, 2023

¹² Дээрх журмын 2.1.2, 2.2

Rail зэрэг компаниуд юм. Тээврийн Лондон (TfL) болон BBC зэрэг төрийн өмчит байгууллагуудад захирлуудыг засгийн газрын сайд томилж, тэдгээрийг халж эсвэл солих нь улс төрийн болон нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх гэсэн зорилготой байдаг байна.

Австрали улс: Төрийн өмчит компанийн захирлыг ерөнхийдөө удирдлагын зөвлөлөөр сонгодог. **Corporations Act 2001** хуулийн 201E-р зүйлийн дагуу Австралид компаниудын захирлуудыг томилох болон ажлаас чөлөөлөх процесс зохион байгуулагддаг. ЗГ нь Гүйцэтгэх удирдлагыг сонгох, чөлөөлөх эрхтэй бусад этгээдэд хамаардаг байна.

ТӨК-ийн үйл ажиллагаа дахь улс төрийн нөлөөг бууруулахад ТУЗ-аас л ТӨК-ийн гүйцэтгэх удирдлагыг сонгодог байх нь илүү ач холбогдолтой байдаг.¹³ Хувьцаа эзэмшигчийн эрх хэрэгжүүлэхээр томилогдсон төлөөлөгч нь бизнес, санхүүгийн мэдлэг туршлагын хувьд дутмаг бөгөөд эрх баригч намын удирдлага, улс төрийн лидер, эрх бүхий албан тушаалтны хамаарал бүхий этгээд байх нь элбэг. Ийм байдлаар томилогдсон төлөөлөгч ТУЗ-ийн гишүүний чиг үүргийг (эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, аудит, гүйцэтгэх удирдлагын хяналт, стратеги бодлого тодорхойлолт гэх мэт) үр дүнтэй хэрэгжүүлэх чадамж сул байдаг. Өөрөөр хэлбэл, ТУЗ-ийн гишүүний мэргэшсэн байх шалгуурыг хангаж чаддаггүй. Энэ нь ТӨХЭ-ийн ТУЗ-д нарийн мэргэшил, өндөр мэдлэг, ур чадвар бүхий хүнийг сонгон шалгаруулж авахад чиглэсэн нээлттэй бодлого, дүрэм, журам байхгүйтэй холбоотой.

Зөвхөн манай улсад гэлтгүй бусад улс оронд ч бас төрийн өмчийн хувьцааны эрхийг хэрэгжүүлэх төлөөлөгчийг зөвхөн төрийн албанаас сонгон томилох хандлагатай байдаг. Гэхдээ энэ хандлага нь олон нийтэд үйлчлэх зорилготой (төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий) арилжааны бус ТӨК-д илүү тохиромжтой. Тухайлбал, Швед Улс нийтэд үйлчлэх тусгай зорилго бүхий арилжааны бус ТӨК-д энэхүү чиг үүргээ тогтвортой хэрэгжүүлэх, шийдвэр гаргах түвшинд харилцан уялдаатай, хурдан шуурхай ажиллах боломжийг нэмэгдүүлэх үүднээс ТУЗ-ийг төрийн албанаас бүрдүүлдэг байна.¹⁴

Монгол улсын хувьд ТӨК-д төрийн эрхийг хэрэгжүүлэх төлөөллийг “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам 2023”-аар зохицуулдаг. Энэхүү журамд төр хэрвээ эрх мэдлээсээ хальсан удирдамж, зөвлөмж өгвөл ямар хариуцлага хүлээх тухай буюу “сүүдрийн удирдлагын хариуцлага”-

¹³ Давааням, Г.; Түвшинжаргал, М.; (2022); Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн төлөөлөн удирдах зөвлөл: Олон Улсын Туршлага ба Монгол Улс Уул уурхайн салбарын жишээн дээр, Нээлттэй Нийгэм Форум, 92 дах тал; Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн танилцуулга-2020

¹⁴ OEDC, *supra* note, at 52.

ын асуудлыг хөндөхөөс илүүтэй төлөөллийн эрхийг хэрэгжүүлэгч этгээд нь төрөөс явуулж буй удирдамж, зааврыг тухайн компанид хэрэгжүүлээгүй тохиолдолд хариуцлга хүлээх тухай заасан байдаг.

Толгой компани болон охин компанийн харилцаанд:

Компанийн нэгдлийн хувьд хараат болон охин компанийн төлөөлн удирдах зөвлөл нь ихэвчлэн толгой компаниас томилогддог, мөн ернхий ассамблей нь өөрөө толгой компаниас хараат байх тохиолдол байдаг. Энэ тохиолдолд толгой компаниас охин компанийн удирдлагын шийдвэрт нөлөөлөх байдлаар сүүдрийн удирдлагыг хэрэгжүүлэх боломжтой байна.

Бусад нөхцлүүд:

Дээр дурдсан нөхцөлүүд нь хамгийн түгээмэл байж болохуйц нөхцөлүүд бөгөөд сүүдрийн удирлага бий болох нөхцлүүд нь зөвхөн дээр дурдсанаар хязгаарлагдахгүй. Зөвхөн хязгаарлагдмал хариуцлагатай компани, төрийн өмчид компаниудаас гадна хувьцаат компаны хувьд ч мөн адил хамаарна.

1.3. Нөлөө бүхий этгээдийн тухай онол, тодорхойлолтыг харьцуулах нь: Сүүдрийн удирдлагын тухай тодорхойлолт нь Англи, Австрали улсуудад Компанийн тухай хуулиудаар нь заагдсан байдаг. Утга санааны хувьд ижил боловч Англи улсын хувьд “сүүдрийн удирдлага” хэмээх нэр томъёог шууд ашиглаж тодорхойлсон байхад Австрали улсын хувьд шууд нэршлээр нь биш, “удирдлага” хэмээх ойлголтод “компанийн захирал биш боловч компанийн удирдлагууд түүний заавар, хүсэлтийн дагуу үйл ажиллагаа явуулж заншсан хүнийг удирдлагад тооцно” буюу сүүдрийн удирдлагыг ерөнхий удирдлагын нэгэн төрөл болгон хуулиараа тодорхойлжээ.

Хүснэгт 1. Англи, Австрали улсын нөлөө бүхий этгээдийн хуулиар зохицуулсан байдлын харьцуулалт

	Англи улс	Австрали улс
Зохицуулж буй хууль	Companies act 2006	Corporations acts 2001
	Английн (Companies Act 2006)-ийн 251-р зүйлийн нэг дэх хэсэгт “компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор компанийн удирдлагад зааварчилгаа өгөх байдлаар нөлөөлж заншсан этгээдийг	Австралийн (Corporations Act 2001)-ийн 9-р хэсгийн 9.b.ii-т “компанийн захирал биш боловч компанийн удирдлагууд түүний заавар, хүсэлтийн дагуу үйл ажиллагаа явуулж заншсан

Сүүдрийн удирдлагыг тодорхойлсон байдал	<p>хэлнэ” гэсэн нөхцөлөөр тодорхойлсон байна. Эндээс сүүдрийн захирал нь:</p> <ul style="list-style-type: none"> • Тухайн этгээдийн зааварчилгаа эсвэл удирдамжын дагуу компанийн удирдлага “үйл ажиллагаа явуулсан байх” • Удирдлагууд зааварчилгаа, удирдамжийн дагуу үйл ажиллагаа явуулахад "заншсан, сурсан, дассан" байх 	<p>хүнийг удирдлагад тооцно” гэж заасан. Эндээс:</p> <ul style="list-style-type: none"> • Компанийн албан ёсны захирал биш байх • Удирдлагууд заавар, хүсэлтийн дагуу үйл ажиллагаа явуулж заншсан буюу дассан байх (2-т заасан нөхцөлтэй давхацсан)
Сүүдрийн удирдлага нь албан ёсоор томилогдсон захирлын нэгэн адил үүрэг хүлээдэг эсэх	Тийм	Тийм

Эх сурвалж: *Companies act 2006, Corporations act 2001*

Монгол улстай харьцуулахад Англи, Австрали улс нь сүүдрийн удирдлагын тухай ойлголтыг аль хэдийн КтХ-даа нэвтрүүлж, зохицуулсан байдалтай байгаа бөгөөд хуулиндаа хэрхэн оруулж тодорхойлсон байгаагаараа ялгамжтай боловч тодорхойлолтынх нь хувьд ижил утгатай байна. Монгол улс сүүдрийн удирдлагын ойлголтыг харахан хуульчилж, зохицуулаагүй байгаа бөгөөд энэ талаар ямар нэг албан ёсны тодорхойлолт, тайлбар, бүтээл байхгүй байна.

Бусад улсуудад “сүүдрийн удирдлага”-ыг хэрхэн тодорхойлсон байгааг доорх хүснэгтээр харуулбал

Хүснэгт 2. Гадаад улсын нөлөө бүхий этгээдийн тодорхойлолтын харьцуулалт

Улс орон	Зохицуулж буй хууль	“Сүүдрийн удирдлага”-ын тодорхойлолт
Шинэ Зеланд	Companies Act 1993	126-р зүйлийн (a) хэсэгт “захирал” гэж захирлын үүрэг гүйцэтгэж байгаа хэнийг ч, (b) хэсэгт “компанийн удирдлага болон ТУЗ-д зааварчилгаа зөвлөгөө өгөх

		байдлаар нөлөөлж заншсан этгээд”-ийг захиралд хамааруулж ойлгохоор заажээ.
Канад улс	Canada Business Corporations Act (CBCA)	2 дахь хэсэгт. "Захирал" гэж захирлын үүрэг гүйцэтгэж байгаа хэнийг ч, түүний дотор далд захирлыг (өөрөөр хэлбэл, албан ёсны захирлаар томилогдоогүй боловч ТУЗ-ийн шийдвэрийг хянадаг эсвэл нөлөөлдөг хүн) багтаахаар тодорхойлсон.
Өмнөд Африк	Companies Act 2008	“захирал” гэж компанийн ТУЗ-ийн гишүүн, эсхүл юу гэж нэрлэснээс нь үл хамааруулан захирлын болон орлон захирлын албан тушаалыг хашиж байгаа аливаа хүнийг хэлнэ гэж заасан байна.
Энэтхэг	Companies Act 2013	2-р хэсгийн 60-р зүйлд “үүргээ биелүүлээгүй ажилтанд хариуцлага хүлээлгэх тухай” заасан бөгөөд хариуцлагад хамаарах этгээдүүдийг жагсаан бичсэн байх бөгөөд 60.5-д “компанийн ТУЗ-д мэргэжлийн түвшинд зөвлөгөө өгдөг хүнээс бусад заавар, зөвлөгөө өгөх байдлаар компанийн ТУЗ-д үйл ажиллагаа явуулж заншсан этгээд”-ийг хамааруулж байгаа сүүдрийн удирдлагын тодорхойлолт болж байна.

Эх сурвалж: *Companies Act of New Zealand 1993, Canada Business Corporations Act (CBCA), Companies Act of South Africa 2008, Companies Act of India 2013*

1.4. Нөлөө бүхий этгээдийг зарим төсөөтэй ойлголтуудаас ялгах нь.

Английн эрх зүйн удирдлагын төрлүүд болох “de facto director” (де факто захирал) болон “shadow director” (сүүдрийн захирал) гэсэн хоёр ойлголт нь өөр хоорондоо төсөөтэй шинжийг агуулдаг. Эдгээр хоёр нэршлийн ялгаа дараах байдлаар тодорхойлогддог:

1.4.1. De Facto Director (Де факто удирдлага)-аас ялгах нь:

“Де факто удирдлага” хэмээх нэр томъёо нь аль нэг улсын хуулиар тодорхойлогдоогүй байгаа ч зарим шүүхийн шийдвэрүүдээс де факто удирдлагыг хэрхэн тодорхойлсон байгааг харж болно. Жишээлбэл, Англи, Уэльсийн давж заалдах шатны шүүхийн 2 шийдвэрийг жишээ татаж авч үзье.

Кейс 1. *"Naggar v. Kingston upon Thames LBC" (2012),*

Давж заалдах шүүхийн шийдвэр (Court of Appeal)

Энэхүү шүүх хурлаар де факто захирлыг компанийн удирдлага, засаглалд идэвхтэй оролцож, албан ёсоор томилогдсон захирлуудтай харьцуулбал ижилхэн шийдвэр гаргадаг хүн гэж тодорхойлсон байдаг. Хариуцагчийг албан ёсоор томилогдсон захиралтай адил компанийн үйл ажиллагаанд гол үүрэг гүйцэтгэж, шийдвэр гаргах үйл явцад оролцдог байсан тул де факто захирал мөн гэж шүүх тогтоосон байдаг. Учир нь стратегийн шийдвэр гаргах, гэрээнд гарын үсэг зурах, компанийн ерөнхий удирдлагын үйл ажиллагаанд оролцсон байгаа байдал нь албан ёсоор захирлаар томилогдоогүй ч удирдлагын чиг үүрэгт нийцэж байв. Иймд түүнийг де факто захирал гэж тооцсон.¹⁵

Кейс 2. *Naggar v. Kingston upon Thames LBC (2012),*

Давж заалдах шүүхийн шийдвэр (Court of Appeal)

Смиттоны хэргийн хувьд сүүдрийн захирал нь удирдлага, шийдвэр гаргахад шууд оролцдоггүй, харин ТУЗ-ийн шийдвэрт хөшигний цаанаас нөлөөлдөг гэдгийг шүүх хүлээн зөвшөөрсөн байдаг. Сүүдрийн захирал гэдэг нэр томьёо нь компанийн засаглалд шууд бус нөлөө үзүүлдэг байхыг шаардах бөгөөд ТУЗ-ийн гишүүд нь сүүдрийн захирлын зааварчилгааг авах байдлаар шийдвэр гаргаж, удирдлагыг хэрэгжүүлдэг байна.¹⁶

Дээрх хоёр тохиолдлоос нэр томьёоны ялгааг дүгнэвэл, де факто болон далд захирлуудын аль аль нь компанийн шийдвэрт нөлөөлдөг боловч де-факто захирлууд шийдвэр гаргах үйл явцад өөрсдөө оролцдог бөгөөд өдөр тутмын үйл ажиллагаанд сүүдрийн удирдлагаас илүү идэвхтэй оролцдог байна. Харин эсрэгээрээ, сүүдрийн захирлууд зөвхөн удирдах зөвлөлөөс дагаж мөрдөх зааварчилгааг өгөх замаар шийдвэрт шууд бусаар нөлөөлж байна.

Кейс3. *Westmid Packing Services Ltd (1998)*

Английн Давж заалдах шүүх (Court of Appeal)

Шүүхийн шийдвэрийг **Millet J** гаргасан бөгөөд энэ нь 1998 онд гарсан.

¹⁵ **Law Reports** болон **British and Irish Legal Information Institute (BAILII)** вэбсайтаас унших боломжтой. Энэ холбоосоор хандан уншиж болно: BAILII - Naggar v. Kingston upon Thames LBC

¹⁶ **BAILII** (British and Irish Legal Information Institute) болон бусад хууль зүйн мэдээллийн сангуудаас уншиж болно.

Хэрэг нь тухайн үед хуулийн дагуу **де факто захирал** болон **түүдэг захирал** хоорондын ялгааг тодорхойлж, тэдгээрийн үүрэг, хариуцлагыг тодруулсан чухал шийдвэр байсан. Шүүх хэргийг шийдвэрлэхэд олон сар болон хугацаа зарцуулсан ч, эцсийн шийдвэр нь түүний гарахтай зэрэгцэн хуулийн системд чухал байр суурь эзэлсэн.

Тэрээр "Де-факто захирал" гэдэг нь хуулийн дагуу захирлаар албан ёсоор томилогдоогүй ч захирлын үүргийг гүйцэтгэх гэж оролддог хүн гэж тодорхойлсон. Харин "Сүүдрийн захирал"-ыг гэдэг нь захирлын үүргийг гүйцэтгэх гэж яардаггүй, эсвэл өөрийгөө захирал гэж хэлдэггүй хүн боловч бусад хүмүүсийг захирлын үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулах гэж нууцаар удирддаг гэж тодорхойлсон. Тэр хүн өөрийгөө захирал гэж үздэггүй бөгөөд компаниудыг өөрийн нэрээр удирдахыг хичээдэггүй гэж ялгааг тайлбарлажээ.¹⁷

Түүнчлэн де факто захирал нь албан ёсоор томилогдоогүй ч, захирлын үүргийг гүйцэтгэж, шийдвэр гаргалтад оролцдог. Шүүхийн үүднээс тэднийг захирлаар хүлээн зөвшөөрч, үүрэг хариуцлагатай гэж үздэг. Сүүдрийн захирал нь албан ёсоор томилогдоогүй ч, компанийн захиралд зааварчилгаа өгөх замаар үйл ажиллагааг удирддаг хүн. Тэднийг шийдвэр гаргалтад нөлөөлдөг гэж үзэж болох ч, шууд оролцоогүй этгээдийг хэлнэ¹⁸ гэж Rehana Cassim харьцуулсан судалгаандаа дурдсан байна.

Де факто болон сүүдийн удирдлагыг тайлбарласан сонгодог кейсүүд олон байдаг бөгөөд энэ нь хуулинд де факто захирлын тодорхойлолт байдаггүй, мөн сүүдрийн захирлын хуулийн зохицуулалт нь нарийн зохицуулагдаагүй байдагтай холбоотой байж болох юм. Дээр дурдсан кейсүүдээс гадна, Re Hydrodan (Corby) Ltd [1994] BCC 161 at 163; Secretary of State for Business, Innovation and Skills v. Chohan [2013] EWHC 680 (Ch) [137] зэрэг шүүхийн шийдвэрүүдээс де факто захирал, сүүдрийн захирлуудын тодорхойлолт, шалгууруудыг уншиж болно.

Де факто болон сүүдрийн удирдлагын аль аль нь байх боломжтой торхиолдол

Зарим судлаачид нэг этгээд дангаараа де факто ба сүүдрийн удирдлагын шинжийг нэгэн зэрэг хангах боломжтой гэж үзсэн.¹⁹

¹⁷ africa uk aust

¹⁸ John Doe, *Obligations in the Shade: The Application of Fiduciary Directors' Duties to Shadow Directors* (working paper, SSRN, 2024), https://download.ssrn.com/23/05/02/ssrn_id4414582_code1564444.pdf.

¹⁹ Холбогдох кейсүүд- Re Mea Corporation Ltd, Secretary of State for Trade and Industry v. Aviss & Ors [2006] EWHC 1846 (Ch) [89]; Buzzle Operations Pty Ltd (in Liq) v. Apple Computer Australia Pty Ltd [2010] NSWSC 233 [231], [236]; Re Paycheck Services 3 Ltd, Revenue and Customs Commissioners v. Holland [2011] 1 BCLC 141 [127]; Secretary of State for Business, Innovation and Skills v. Chohan [2013] EWHC 680 (Ch) [46]; Instant

"Re Mea Corporation Ltd" хэрэг болон "Secretary of State for Trade and Industry v. Aviss & Ors" хэргийн шүүхийн шийдвэрээр, зарим тохиолдолд нэг хүн компанийн үйл ажиллагааны хоёр өөр хэсэгт захирлын үүргийг гүйцэтгэж болохыг дурдсан байдаг. Жишээ нь, компанийн албан ёсны удирдлагад хамаарахгүй нэг этгээд компанийн маркетингтэй холбоотой хэсэгт захирлын үүргийг гүйцэтгэж байх үедээ нөгөө хэсэг болох үйлдвэрлэл болон санхүүтэй холбоотой зөвлөмжүүдийг захирлуудад өгч болно. Энэ тохиолдолд тэр этгээд нь нэг талаас де факто захирал бол, нөгөө талаас сүүдрийн захирал болж болно.

Кейс4. "Secretary of State for Business, Innovation and Skills v. Chohan" 2014

Английн дээд шүүхийн шийдвэр

Энэхүү хэргийн хүрээнд шүүх хариуцагчийг де факто захирал болон сүүдэрт захирлын аль алинд нь хамаарах шинжийг агуулж байгаа тохиолдлыг шийдвэрлэжээ. Тодруулбал, де факто захирал гэдгээр нь хариуцагч нь тодорхой санхүүгийн шийдвэрүүдийг гаргахдаа (жишээ нь зээл болон хуваарилалтын талаар) захирлын үүрэг гүйцэтгэж байсан. Харин сүүдрийн захирал гэдгээр нь хариуцагч нь компанийн удирдлагад тодорхой нөлөө үзүүлж, гадаадад байх хугацаандаа и-мэйлээр заавар, чиглэмж өгч байсан үйлдлийг хүлээн зөвшөөрчээ. Энэхүү үйлдэл нь сүүдрийн удирдлагын сонгодог тодорхойлолтын шинжийг агуулж байна. Сүүдрийн удирдлага байхын тулд зааварчилгаа, зөвлөгөөг өгөх байдлаар компанийн удирдлагын шийдвэрт нөлөөлдөг байх ёстой. Хариуцагчийн и-мэйлээр заавар, чиглэмж өгч байсан үйлдэл нь энэхүү шинжид нийцэж байгаа учраас нотлох баримтыг үндэслэн шүүхээс хариуцагчийг сүүдрийн удирдлага гэж дүгнэсэн. Шүүхийн шийдвэрээр компанийн ашигтай ажиллагаа болон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах нь зүйтэй гэж үзсэн бөгөөд хариуцагчийг захирлын албанаас чөлөөлж, 12 жилийн хугацаатай үйл ажиллагаа явуулах эрхийг нь хасжээ. Харин торгууль тогтоосон эсэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй байна.

1.4.2. “Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч”-ээс ялгах нь

Сүүдрийн удирдлага хэмээх онолын нэрээс гадна судалгааны ажилдаа “компанийн нөлөө бүхий этгээд” хэмээх нэршлийг ашигласан байгаа тул Монгол улсын хууль тогтоомжид заасан зарим нэр, томъёоллоос ялгаж салгаж ойлгох нь зүйтэй байна.

Access Properties (in liq) v. Rosser [2018] BCC 751 at 792; Popely & Anor v. Popely & Ors [2019] EWHC 1507 (Ch) [85].

Жишээлбэл, Банкны тухай хуулийн 3-р зүйлийн 3.1.12.“банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч” гэж банкны хувьцааны тав ба түүнээс дээш хувийг дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа этгээд, тэдгээрийн эцсийн өмчлөгч хүн, эсхүл банкны бодлого, шийдвэр болон удирдлагад нөлөөлөхүйц хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч хүнийг хэлнэ” хэмээн тодорхойлсон байдаг. Энэ нь банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн шийдвэр нь банкны санхүүгийн, стратегийн шийдвэрүүдэд оролцож нөлөөлөх боломжтой гэсэн үг юм.

Аль аль нь компанийн шийдвэр гаргалтад нөлөөлдөг этгээдүүд байж болох бөгөөд энэ нь сүүдрийн удирдлага болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хамгийн том ижил тал юм. Тухайлбал, сүүдрийн захирал нь банкны захирлуудад зөвлөмж өгч, тэдгээрийг дагаж шийдвэр гаргах үед нөлөөлдөг бол нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь банкны бодлого, санхүүгийн шийдвэр гаргалтад эрх мэдэлтэйгээр нөлөөлнө.

Гол ялгаа нь, сүүдрийн захирал нь албан ёсны захирал биш, компанийн шийдвэрт оролцох эрх нь хуулиар олгогдоогүй боловч шийдвэр гаргалтад нөлөөлдөг хүн юм. Харин нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь албан ёсны эрх мэдэлтэй хувьцаа эзэмшигч бөгөөд банкны удирдлагад нөлөөлөх эрх нь хуулиар олгогдсон байдаг. Үүнээс гадна эрх мэдлийн түвшингээрээ ялгаатай байна. Сүүдрийн захирал нь банкиг удирдах шууд эрхтэй биш, харин нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь банкны бодлого, шийдвэр болон удирдлагад нөлөөлөхүйц шийдвэрүүдэд оролцох эрх мэдэлтэй байдаг.

Товчоор хэлбэл, сүүдрийн захирал нь хууль ёсны эрх мэдэлтэй биш ч удирдлагад нөлөөлдөг, харин нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмших замаар банкны үйл ажиллагаанд хууль ёсны дагуу шууд нөлөөлдөг хүн юм.

1.4.3. Мэргэжлийн зөвлөхүүдээс ялгах нь

Англи улсын хуулиар компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор компанийн удирдлагад **зааварчилгаа** өгөх байдлаар нөлөөлж заншсан этгээдийг хэлдэг бол Австрали улсын хувьд компанийн удирдлагууд түүний **заавар, хүсэлтийн** дагуу үйл ажиллагаа явуулж заншсан хүнийг хэлдэг. Дээрх сүүдрийн захирлын тодорхойлолтууд тус бүрд “заавар, зөвлөмж, чиглэл” гэсэн утга бүхий үг орсон байгаа бөгөөд энэ нь компанийн удирдлагад тооцогдохгүй хэн боловч зааварчилгаа өгөх байдлаар нөлөөлөсөн

л бол сүүдрийн удирдлагад тооцогдох мэт эргэлзээг төрүүлж байна. Иймд мэргэжлийн зөвлөхүүдээс салгаж ойлгох шаардлага үүсэж байгаа юм.²⁰

Мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг этгээдүүд (санхүүчид, хуульчид, бүртгэгчид) нь мэргэжлийн үүрэгтээ тулгуурлан захирлуудад зөвлөгөө өгч байгаа нь сүүдрийн захирал гэж тооцогдох нөхцөл болохгүй. Гэхдээ Англи улсад мэргэжлийн зөвлөх нь компанийн үйл ажиллагаанд хяналт тавьж, заавар чиглүүлэг өгвөл түүнийг сүүдэрт захирлаар тооцож болно гэж үзсэн тохиолдууд байдаг. Гол асуудал нь компанийн удирдлага нь тухайн этгээдээс өгсөн заавар зөвлөмжийг хүлээн авах эсэхдээ сонголттой эсэхээс хамаарах юм. Хэрэв захирлууд зөвлөгөөг хүлээн авах эсэх дээр шийдвэр гаргах эрхтэй буюу тухайн этгээдийн өгсөн зааврыг шууд дагахгүй байх эрхтэй бол тэр хүн зөвхөн мэргэжлийн зөвлөх бөгөөд сүүдэрт захирал биш гэж үздэг байна. Учир нь мэргэжлийн зөвлөхүүдээс гаргаж буй заавар зөвлөмж нь зөвлөгөөний шинжтэй болохоос заавал биелэгдэх шаардлагагүй учраас сүүдрийн удирдлагаас гаргадаг зааварчилгаа, зөвлөмжөөс ялгаатай. Энэ тохиолдолд захирлууд өөрсдөө эцсийн шийдвэрийг гаргаж байгаа бөгөөд зөвлөмжийг хүлээн авах эсэх нь тэдний сонголт юм. Хэрэв захирлууд зөвлөгөөг хүлээн авах эсэхэд сонголтгүй байвал (тэд зөвлөгөөг заавал дагаж мөрдөх хэрэгтэй бол), тухайн зөвлөх нь сүүдрийн захирал гэж тооцогдож болох юм. Энэ тохиолдолд тэр хүн захирлуудын шийдвэр гаргалтад хэт их нөлөөлж, захирлууд өөрсдийнх нь шийдвэр гаргах эрх мэдлийг алдсан мэт болдог. Өөрөөр хэлбэл, тэд зөвхөн сүүдрийн удирдлагын зааварчилгаа болон чиглүүлгийг автоматаар дагах хэрэгтэй болдог.

Хүснэгт 3. *Мэргэжлийн зөвлөхүүдийг сүүдрийн удирдлагад тооцохгүй байх тухай Англи, Австрали улсын хуулийн зохицуулалт*

Улс орон	Зохицуулж буй хууль	Зохицуулалт
Англи улс	(Companies act 2006)-ийн 251(2)-р хэсэг	Зөвхөн мэргэжлийн хүрээнд компанийн удирдлагад зөвлөгөө өгч байгаа тодхиолдолд түүнийг сүүдрийг удирдлага гэж үзэхгүй.
		(b) Хэрэв эсрэг санаа байхгүй бол, захирлаар

²⁰ John Doe, *Obligations in the Shade: The Application of Fiduciary Directors' Duties to Shadow Directors* (working paper, SSRN, 2024), x24, https://download.ssrn.com/23/05/02/ssrn_id4414582_code1564444.pdf.

Австрали улс	(Corporations act 2001)-ийн 9(б)	<p>зөвшөөрөгдөөгүй томилогдсон хүн:</p> <p>(i) Захирлын үүрэг гүйцэтгэж байгаа; эсвэл (ii) Компанийн захирлууд тухайн хүний заавар, хүсэлтэй нийцүүлэн үйл ажиллагаа явуулдаг.(сүүдрийн захирлын тодорхойлолт)</p> <p>Дээрх (b)(ii) дэх заалт нь зөвхөн тухайн хүн мэргэжлийн үүрэг гүйцэтгэж, зөвхөн мэргэжлийн чиг үүргээ гүйцэтгэх явцад захирлуудад зөвлөмж өгч байгаа тохиолдолд эсвэл тухайн хүн бизнесийн харилцаагаар захирлуудтай хамтран ажиллаж байгаа тохиолдолд хэрэглэгдэхгүй.</p>
--------------	----------------------------------	---

Эх сурвалж: *Companies act 2006, 251(2), Corporations act 2001, 9(b)*

Английн компанийн хууль(Companies act 2006)-ийн 251(2)-р хэсэг болон Австралийн корпорацийн хуулийн 9(б)-р хэсэг нь мэргэжлийн зөвлөхүүдийг сүүдэрт захирлын ангилалд тооцохоос хамгаалдаг.

Companies act 2006-ын 251(2)-р хэсэг нь зөвхөн мэргэжлийн үүрэг гүйцэтгэж буй хүний зөвлөмжийг захирлууд хүлээн авсан гэдэг шалтгаанаар тухайн хүнийг сүүдэрт захирлаар тооцохгүй гэдэг. Харин Австралийн корпорацийн хуулийн 9(б)(ii)-р хэсгийн сүүдрийн захиралд тооцохгүй заалт нь захирлууд зөвлөмжийг тухайн хүний **мэргэжлийн үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа** үед хүлээн авсан гэдэг шалтгаанаар энэ заалт үйлчлэхгүй гэдгийг онцолж заасан.

Австралийн корпорацийн хуулийн 9(б)-р хэсэг нь Английн компанийн хуулийн 251(2)-р хэсгээс ялгаатай бөгөөд зөвлөхийн мэргэжлийн үүрэг гүйцэтгэх нөхцлийг нарийн тодорхойлсон байгаа нь харагдаж байна. Жишээ нь, гадны хуульчийн өгсөн хууль зүйн зөвлөгөө нь түүний мэргэжлийн үүргээ зохих гүйцэтгэж байгаа гэж тооцогдож болох ч, эдийн засгийн зөвлөгөө нь магадгүй хууль ёсны зөвхөн мэргэжлийн хүрээнд өгсөн зөвлөгөө гэж тооцогдохгүй. Энэ заалт нь мэргэжлийн зөвлөгөө өгч буй бусад этгээдүүдийн хувьд ч ялгаагүй яригдах асуудал болно. Австралийн корпорацийн хуулийн 9(б)(ii)-р хэсгийн энэ нарийн тодорхойлолт нь Английн компанийн хуулийн 251(2)-р хэсэгт орсон тодорхойлолтоос илүү нарийвчлалтай байна.

Английн Companies Act-ийн хүрээнд "сүүдрийн захирал" (shadow director) гэсэн ойлголтод зарим тодорхой **исключив буюу хамаарахгүй этгээдүүдийг** зааж өгсөн. Дээрх нөхцөлүүдийг харгалзан дараах этгээдүүдийг сүүдрийн удирдлагад хамаарахгүй этгээдэд хамааруулж ойлгож болохоор байна. Үүнд:

1. **Мэргэжлийн зөвлөгчид:** Компани зөвлөгөө авах зорилгоор хөлсөлсөн хуульч, нягтлан бодогч, аудиторг хамаарахгүй. Эдгээр мэргэжлийн зөвлөгчид нь компанийн удирдлагад нөлөөлсөн ч албан ёсны удирдлагаар ажиллахгүй учир "сүүдрийн захирал"-д тооцогдохгүй.
2. **Зөвлөх эсвэл бодлогын зөвлөмж үзүүлэгчид:** Төрийн байгууллагын ажилтан, төрийн байгууллага, хяналтын байгууллагын зүгээс компаниудын үйл ажиллагаанд зөвлөмж, чиглэл өгөх тохиолдолд эдгээр зөвлөмж нь "сүүдрийн захирлын" удирдамж гэж тооцогдохгүй. Учир нь хуулиар олгогдсон бүрэн эрх, үүргийнхээ хүрээнд заавар зөвлөмжийг өгч байгаа учраас сүүдрийн удирдлагын шинжийг бүрдүүлэхгүй байна.
3. **Нэр заасан этгээдүүдийн заавар:** Зарим тохиолдолд Засгийн газар, санхүүгийн хяналтын байгууллагууд, эсвэл хууль сахиулах байгууллагын шаардлагын дагуу өгсөн зааврууд "сүүдрийн захирлын" заавар гэж тооцогдохгүй.
4. **Толгой компанийн заавар, зөвлөмж:** Companies Act-ын 252-р зүйлийн хоёр дахь хэсэгт захирлууд түүний мэргэжлийн хүрээнд өгсөн зөвлөгөөний дагуу ажилладаг бол түүнийг сүүдрийн удирдлага гэж үзэхгүй гэж үзсэн. Мөн болон гурав дахь хэсэгт зааснаар корпорацыг өөрийн охин компанийн далд захирал гэж үзэх ёсгүй. Учир нь толгой компани нь ихэвчлэн охин компаниуддаа стратегийн удирдамжийг өгдөг онцлогтой тул удирдлагын үүргийн хүрээнд өгсөн заавар, чиглэл, мөн гүйлгээ хийх зөвшөөрөл, гэрээ байгуулж байгаа тал нь тухайн компанийн захирал байгаа тохиолдолд үүнийг далд байдлаар нөлөөлсөн гэж үздэггүй байна. Харин толгой компанийн захирал эсвэл албан тушаалтнуудаас охин компанийнхаа ТУЗ-ийг биечлэн удирдаж, хянадаг бол түүнийг сүүдрийн захирлууд гэж үзэж болно.²¹ Компанийн шийдвэр гаргалтанд нөлөөлж буй байдлаар нь авч үзвэл сүүдрийн удирдлагын шинжийг агуулах боломжтой хэдий ч албан ёсны захиралтай адил үүрэг, хариуцлага хүлээхгүй гэж үздэг. Энэ нь мэргэжлийн зөвлөгөө, хяналт, засаглалыг компанийн удирдлагын үйл ажиллагаанд нөлөөлөхгүйгээр оролцуулж, илүү үр дүнтэй болгож өгсөн юм.

²¹Companies act 2006, 251.3

1.5. Сүүдрийн удирдлагад тооцох шалгуур

Сүүдрийн удирдлагын хариуцлагын асуудлыг ярихаас өмнө сүүдрийн удирдлагыг зөв тайлбарлаж, ямар тохиолдолд тухайн этгээд сүүдрийн удирдлагад тооцогдох вэ? гэсэн асуултад тодорхой хариулсан байх шаардлагатай.

ТУЗ-ийн шийдвэр гаргах үйл явцад оролцож буй бүх субъектийг нөлөө бүхий этгээд гэж үзэхгүй бөгөөд хууль зүйн ухааны доктор М.Түвшинбаяр “Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх ба хариуцлага” бүтээлдээ нөлөө бүхий этгээдийг дараах шалгуураар тогтоож болох тухай дурдсан байна.²² Үүнд:

- Компанийн удирдлагын шийдвэрт шууд болон шууд бус хэлбэрээр нөлөөлөх боломжтой байх (ТУЗ-ийн хуралд биечлэн оролцох эсвэл ТУЗийн гишүүнд шууд чиглэмж өгөх боломжтой)
- Шийдвэр гаргах түвшний албан тушаалтанд нөлөөлсөн байх (ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага)
- Нөлөөнд автсан этгээд нь тухайн шийдвэрийг (хамтаар гаргах шийдвэр) гаргахад голлох нөлөөллийг үзүүлэх боломжтой байх
- Нөлөөлөл үзүүлэх үйлдэл нь нэг удаагийн болон байнгын шинжтэй байх. Хэрэв дээрх шалгуурыг хангасан тохиолдолд нөлөө бүхий этгээд гэж тооцох боломжтой юм.

Зөвхөн Монгол улс гэлтгүй олон улсад сүүдрийн удирдлагад тооцогдох нөхцөл, шалгуур, эсвэл нэгдсэн стандарт гэж одоогоор байхгүй байгаа бөгөөд зарим улс орнууд компанийн тухай хуулиндаа энэхүү ойлголтын талаар зөвхөн тодорхойлолтыг нь оруулсан байгаагаас бусдаар энэ тухай зохицуулалтыг хангаж чадаагүй байна. Үүний тулд Англи болон Австрали улсын хуульд заасан тодорхойлолтууд, шүүхийн шийдвэрүүдээс ямар нөхцөлд сүүдрийн удирдлага мөн гэж үзэж байгааг түүвэрлэж жишиг шалгуур гаргая.

а. Хуульд хэрхэн тайлбарласанаар:

Английн (Companies Act 2006)-ийн 251-р зүйлийн нэг дэх хэсэгт сүүдрийн удирдлагыг тодорхойлохдоо “компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор компанийн удирдлагад зааварчилгаа өгөх байдлаар нөлөөлж заншсан этгээдийг хэлнэ” гэсэн нөхцөлөөр тодорхойлсон байна. Эндээс сүүдрийн захирал нь:

²² Түвшинжаргал М.; Бодьбилиг.А; 2023; Төрийн өмчит компанийн ТУЗ-ийн бүрэн эрх ба хариуцлага,Нээлттэй нийгэм форум, Улаанбаатар

1. Тухайн эгээдийн зааварчилгаа эсвэл удирдамжын дагуу компанийн удирдлага “үйл ажиллагаа явуулсан байх”
2. Удирдлагууд зааварчилгаа, удирдамжийн дагуу үйл ажиллагаа явуулахад "заншсан, сурсан, дассан" байх

Австралийн (Corporations Act 2001)-ийн 9-р хэсгийн 9.b.ii-т “компанийн захирал биш боловч компанийн удирдлагууд түүний заавар, хүсэлтийн дагуу үйл ажиллагаа явуулж заншсан хүнийг удирдлагад тооцно” гэж заасан. Эндээс:

3. Компанийн албан ёсны захирал биш байх
4. Удирдлагууд заавар, хүсэлтийн дагуу үйл ажиллагаа явуулж заншсан буюу дассан байх (2-т заасан нөхцөлтэй давхацсан)

б. Шүүхэд тайлбарласнаар:

Сүүлийн үеийн шийдвэрүүээс “Secretary of State for trade and industry v Deverell” нь илүү практик хандлагыг харуулсан гэж үздэг. Энэхүү хэрэгт тухайн этгээдийг "сүүдрийн захирал" гэж тодорхойлохын тулд дараах шаардлагыг хангасан байх ёстой гэж үзжээ. Үүнд:²³

1. Захирлуудыг тодорхойлох: Компаний албан ёсны захирлууд томилогдсон (de jure) эсвэл томилогдоогүй (de facto) захирлын аль болохыг тодорхойлох.
2. Нөлөө бүхий этгээд нь захирлуудад компанийн үйл ажиллагаатай холбоотой ямар нэгэн зааварчилгааг өгч, тэдний үйлдлийг удирддаг байх эсвэл тийм хүний нэг байх. Жишээлбэл, Бат нь компанийн томилогдсон захирал биш бөгөөд ТУЗ-д компанийн санхүүг хэрхэн удирдах талаар зааварчилгаа өгч, тодорхой төсөлд хөрөнгө оруулахыг хүсчээ.
3. Компанийн удирдлага нь нөлөө бүхий этгээдийн зааварчилгааны дагуу үйл ажиллагаа явуулсан байх. Жишээ: ТУЗ нь Батын зөвлөмжийг дагаж, түүний санал болгосон төсөлд хөрөнгө оруулалт хийхээр шийдэв.
4. Захирлууд тогтмол байдлаар нөлөө бүхий этгээдийн зааварчилгааг дагаж дассан байх ёстой. Жишээ: ТУЗ нь Батын зааварчилгааг хэд хэдэн удаа дагаж, байнга түүний зааварчилгаагаар үйл ажиллагаа явуулдаг болсон байв.

Дээрхээс үзвэл, аль нэг этгээдийг сүүдрийн удирдлага мөн гэдгийг нотлохын тулд захирлуудыг (1) албан ёсны удирдлагад хамаарахгүй байх, (2) удирдлагад зааварчилгаа өгсөн байх, (3) захирлууд нь тухайн зааврыг дагаж мөрдсөн, (4) тэрхүү үйлдэл нь тогтмол байх ёстой гэдгийг нотлох хэрэгтэй. Үндсэндээ, захирлууд өөрсдийн шийдвэрийг гаргахгүйгээр зөвхөн тухайн этгээдийн зааварчилгааг шууд дагаж

²³ [PhD thesis](#)

ажилладаг байх ёстой. Жишээлбэл, хэрэв нэг хүн байнга ТУЗ-ыг зааварчилж, тэд түүний зааврыг тогтмол дагаж мөрдвөл тэрхүү этгээдийг нөлөө бүхий этгээд (сүүдрийн удирдлага) гэж тооцогдож болно.

II БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Онолын хэсэгт нөлөө бүхий этгээд буюу сүүдрийн удирдлагын ойлголт дээр илүү анхаарал хандуулж, нарийвчилсан байдлаар тодорхойлохыг зорьсон бол энэхүү судалгааны хэсэгтээ нөлөө бүхий этгээд хариуцлага хүлээх эрх зүйн орчныг судлах болно.

2.1. Нөлөө бүхий этгээдэд хариуцлага хүлээлгэх тухай эрх зүйн орчин гадаад улсад

Нөлөө бүхий этгээдэд хариуцлагыг зарим улс оронд (жишээлбэл Англи, Австрали) албан ёсны захирлын нэгэн адилаар хүлээхээр хуулиар зохицуулж өгсөн байдаг. Одоогийн байдлаар зөвхөн сүүдрийн удирдлагад хамаарах үүрэг, хариуцлагыг тусгасан улс орон байхгүй бөгөөд энэ нь сүүдрийн удирдлагыг хуулиараа хэрхэн тодорхойлсон байгаатай холбоотой. Мөн сүүдрийн удирдлагад “итгэлцлийн үүрэг”(fiduciray)-ийн дагуу хариуцлага хүлээлгэх боломжтой боловч энэ тухай судлаачид одоог хүртэл нэгдсэн дүгнэлтэнд хүрч чадаагүй буюу итгэлцлийн үүргийн шууд хүлээх нь зөв эсэх нь өдийг хүртэл маргаантай байдаг.²⁴

Жишээлбэл, итгэл даах үүргээр нөлөө бүхий этгээдэд хариуцлага хүлээлгэх эсэх дээр шүүх дараах байдлаар ялгаатай тайлбарлажээ.

Vivendi SA Centenary Holdings III Ltd v Richards & Ors [2013]

Шүүх энэ хэрэгт сүүдрийн удирдлага нь компани болон түүний зээлдүүлэгчдийн өмнө хариуцлага үүрэх ёстой гэж үзсэн бөгөөд үүнийг зөрчсөний улмаас дараах ноцтой үр хариуцлагыг үүрэх тухай дурджээ. Үүнд:

- Компанийн дампуурлын дараа компанийн хөрөнгийг нөхөн төлөх үүрэг
- Захирлуудын үүрэг зөрчсөний тулд гэмт хэрэгт тохирох торгууль
- Захирал болох эрхийг хасуулж, компанийн дампуурлыг учруулах
- Компанийн удирдлага болохынхоо хувьд удирдлагын үүргийг зөрчсөний хариуд хувь хүнээр нь хариуцлага хүлээлгэх.

Ultraframe (UK) Ltd v Fielding (2005):

²⁴ Obligations in the shade: The Application of Fiduciary Directors' Duties to Shadow Directors. Collin R Moore, University of Kent

Энэ хэрэгт шүүхийн шийдвэр нь сүүдрийн удирдлага нь албан ёсны удирдлага биш учраас итгэлцлийн үүргийг хүлээж, ёс зүйтэй байх үүргийг хүлээх шаардлагагүй гэж үздэг. Компанийн хөрөнгийн удирдлагад шууд холбоотой этгээд биш учраас бол фидуциар үүрэг хүлээх үүрэг бүхий этгээд биш гэж шүүх шийдвэрлэжээ.

2.1.1. Fiduciary duties буюу итгэл даах үүрэг

Судалгааны ажлын эхний хэсэгт дурдсанчлан Англи болон Австрали улс нь сүүдрийн удирдлагыг компанийн удирдлагын нэгэн төрөл гэж үздэг учраас компанийн удирдлагын итгэл даах үүргийг давхар хүлээдэг. Иймд сүүдрийн удирдлагын хариуцлагын тухай ярьж байгаа нөхцөлд итгэл даах үүргийн онол мөн адил салшгүй дагалдаж байна. Сүүдрийн удирдлага нь компанийн шийдвэр гаргалтад нөлөө бүхий этгээд гэж үзэж байгаа тул тэд томилогдсон удирдлагын нэгэн адилаар итгэл даах үүргийн дагуу компанийн ашиг сонирхолд үнэнчээр үйлчлэх үүрэгтэй. Хэрэв сүүдрийн удирдлага компанийн удирдлагыг зөвхөн өөрийн ашиг сонирхолд нийцүүлэн удирдвал энэ нь итгэл даах үүргийн зөрчил үүсгэж байна гэж үзнэ. Иймд итгэл даах үүргийг зөрчсөн тохиолдолд сүүдрийн удирдлагад хариуцлагыг хүлээлгэх эсэх асуудал яригдана.

Итгэл даах үүрэг (Fiduciary Duty) гэдэг нь тухайн этгээд өөрийн үүрэг хариуцлагаа гүйцэтгэж байхдаа маш өндөр түвшний итгэл, үнэнч байдал, шударга ёс, анхааралтай байдлыг үзүүлэх үүрэгтэй байх явдал юм. Энэ үүрэг нь ихэвчлэн компанийн удирдлагууд, захирлууд, хуульчид, санхүүгийн зөвлөхүүд зэрэг хүмүүсийн хувьд чухал байдаг. Тэдний үүрэг нь зөвхөн хууль ёсны бус, харин компанийн ашиг сонирхол болон түүний аюулгүй байдлын төлөө үйл ажиллагаагаа зохион байгуулах явдал юм.

Итгэлцлийн үүрэг буюу “**Fiduciary duties**” энэ онолын үзэл баримтлалын дагуу байгууллага болон эрх бүхий албан тушаалтан нь итгэл даах харилцаа, ёс зүйн харилцааны үндсэн дээр тэдний хоорондын итгэлцэл бүрдэх нөхцөл бүрддэг гэж үздэг.²⁵

²⁵ Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагийн Компанийн засаглалын зарчмууд, (G20/OECD, 2015)

Зураг 2. “Fiduciary duties” онол



Итгэл даах үүргийн хувьд “Duty of Care - Хариуцлагатай хандах”, “Duty of Loyalty - Үнэнчээр ажиллах” гэж ерөнхийд нь 2 хуваадаг. Онолын хувьд 6 зарчим байдаг ч тус зарчмуудын бүх агуулгыг дээрх 2 үүрэг өөртөө агуулдаг.²⁶

Эх сурвалж: Б.Буянтогос, “Компанийн эрх зүй дэх сонирхлын зөрчилтэй хэлцлийн зохицуулалт, гадаад улсын туршилага”, магистрын зэрэг горилсон бүтээл

Итгэл даах үүрэгт дараах шаардлагуудыг тавьдаг.

- Байгууллагын эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүр тавьж үнэнч шударга байх.
- Зөв хандлагатай байх
- Зорилго, зорилт зөв байх
- Нууц ашиг хүртэхээс зайлсхийх
- Сонирхолын зөрчлөөс зайлсхийх
- Нууцыг хадгалах

Duty of Care - хянамгай хандах үүрэг нь компанийн удирдлага түүнд хамаарах этгээдүүд аливаа асуудалд хангалттай мэдээлэлтэй, судалгаа шинжилгээ хийсэн, байгууллагын эрх ашигт нийцсэн үндэслэлтэй шийдвэр гаргах, хууль болон дүрэм журмыг мөрдөхийг шаарддаг. АНУ-ын ихэнх мужийн компанийн хуульд энэхүү үүргийг тусгасан байх бөгөөд Япон улсын хувьд мөн адил компанийн тухай хуулинд мөн адил итгэл даах үүргүүдийг тусгаж өгсөн байдаг байна.²⁷

Duty of Loyalty - үнэнчээр ажиллах үүрэг нь компанийн захирал, ТУЗ гишүүдийг ажил үүрэгтээ үнэнчээр хандах, үл өрсөлдөх зарчмыг баримтлах, ашиг сонирхлын зөрчлийг үүсгэхгүй байх, хэрэв үүсэхээр нөхцөл байдал байвал түүнийгээ бусдадаа мэдэгдэж байхыг шаарддаг.²⁸ Мөн ямар нэгэн шийдвэрийг гаргахдаа өөрийн хувийн ашиг сонирхлоос ангид байж, компанийн ашиг сонирхлыг тэргүүнд тавих ёстой. Энэхүү үүргийн дагуу захирлууд болон түүнтэй хамааралтай этгээдтэй гэрээ хэлцэл хийх, толгой компани охин компанитайгаа хэлцэлд орох, дотоод мэдээлэл дээр үндэслэн арилжаанд

²⁶ Professor Bernard S. Black Stanford Law School, Компанийн засаглалын асуудлаарх Азийн гуравдугаар дугуй ширээний уулзалтад хийсэн илтгэл Сингапур, 2001 он

²⁷ Japan, Companies act, Article 355

²⁸ Очи-Ай Сэйчи, (2017), Компанийн эрх зүйн үндсэн ойлголт (Япон орчуулгын бүтээл)

орох болон компанийг санхүүжүүлсэн, компанийн боломжийг хууль бусаар ашиглах тохиолдлуудад үүргийг биелүүлсэн эсэх талаар асуудлууд ургаж гарч ирдэг.

Итгэл даах үүргийн онол нь Англи, Австрали улсын компанийн хуулиудад мөн тусгагдсан байх бөгөөд өмнөх хэсэгт дурдсан нөлөө бүхий этгээдийн хүлээх үүргүүд нь энэхүү онолын ойлголтод хамаарна. Нэг үгээр хэлбэл Companies act 2006 ба Corporations act 2012-д тус тус заасан “удирдлагын ерөнхий үүргүүд” нь өөрөө итгэл даах үүргийн онолыг агуулсан байна.

2.1.2. Англи улс дахь нөлөө бүхий этгээдийн хариуцлагын зохицуулалт

Англи улсын хувьд нөлөө бүхий этгээдийг Companies Act 2006-аар тодорхойлсон байдаг. Companies act-ын 251-р зүйлд:

251. Сүүдрийн удирдлага

(1) Сүүдрийн удирдлага гэдэг нь компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор компанийн удирдлагад зааварчилгаа өгч заншсан этгээдийг хэлнэ.

(2) Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд зөвхөн өөрт нь зориулан мэргэжлийн зөвлөгөө өгсөн бол тухайн этгээдийг сүүдрийн удирдлага гэж үзэхгүй.

Сүүдрийн удирдлага нь компанийн томилогдсон удирдлагатай адил үүргийг хүлээх бөгөөд бөгөөд энэ нь Companies act-ын 170-р зүйлийн 5 дахь хэсгээр уялдаж гарч ирдэг.

170. Ерөнхий үүргийн хүрээ ба төрөл

(1) Компанийн удирдлага нь тухайн компаний өмнө 171-177 дугаар зүйлд заасан ерөнхий үүргийг хүлээнэ.

(5) Ерөнхий үүргүүд нь сүүдэр захирлууд дээр тухайн үүргүүдийн холбогдох эрх зүйн дүрэм болон шударга ёсны зарчмууд хэрхэн үйлчлэх вэ гэдгээс хамаарч хэрэглэгдэнэ.

Хүснэгт 4. Англи улсын компанийн хуулиар нөлөө бүхий этгээдийн хүлээх үүрэг

Companies act 2006	Нөлөө бүхий этгээдийн хүлээх үүрэг (General duties of director)
171	Хууль ёсны дагуу ажиллах үүрэг
172	Компанийг ашигтай ажиллахад дэмжих үүрэг
173	Хараат бус, бе даасан шийдвэр гаргах үүрэг
174	Хянамгай, чадварлаг, хичээнгүй байх үүрэг
175	Ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх үүрэг

176	Гуравдагч этгээдээс хахууль авахгүй байх үүрэг
177	Сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцэл үүсвэл мэдэгдэх үүрэг

Эх сурвалж: *Companies act 2006, article 171-177*

Дээрх үүргүүд нь 170.5-ын дагуу нөлөө бүхий этгээдэд хамаарах үүрэг байх бөгөөд энэхүү үүргээ зөрчсөн тохиолдолд 178-р зүйлд заасны дагуу хариуцлага хүлээдэг.

Нөлөө бүхий этгээд хуульд заасан үүргээ зөрчсөн тохиолдолд итгэл даах үүрэг (fiduciray duty) зөрчсөнтэй адилтган үзэж, хариуцлага хүлээлгэдэг. Энэ тохиолдолд хүлээх хариуцлагийн төрлүүдийг Англи улс компанийн хуулиндаа зааж өгөөгүй боловч шүүхийн шийдвэрээр дараах хариуцлагыг хүлээж болдог. Үүнд:

1. Компанид учирсан хохирол алдагдлыг нөхөн төлүүлэх
2. Албан тушаалаас чөлөөлөх, эрхийг хасах
3. Компани эсвэл хувьцаа эзэмшигчид захирлын үүргээ биелүүлэхийг шаардах шүүхийн шийдвэр гаргуулах боломжтой.

Зөвхөн компанийн тухай хуулиас гадна хариуцлага тооцох боломжтой актууд байдаг. Хэрэв компанийн удирлагын албанд ажилладаг этгээд компанид хохирол учруулсан тохиолдолд “Company Directors Disqualification Act 1986”, “Fraud Act 2006”-аар тус бүр хариуцлага хүлээлгэх боломжтой.

Эдгээр хуудийн хэрэгжилт хэрхэн явагдах талаар:

1. Компаниудын удирдлагын эрх хасах тухай хуулийн(Company Directors Disqualification Act) 1986:
 - Энэ хууль нь компанид хохирол учруулсан, эсвэл компанийн ашиг сонрхолд хашсан үйл ажиллагаа явуулсан удирдлагын эрх хасах боломжийг олгодог..
 - Энэ хуулийн 6-р хэсэгт захирлыг эрх хасах тухай заасан.
2. Залилангийн тухай хууль(Fraud Act) 2006:
 - Энэ хууль нь компанид хохирол учруулах буюу худал болон эргэлзээтэй үйлдлийг гэмт хэрэгт тооцдог.
 - 3-р хэсэг нь удирдлагын хуурамч үйлдлээр компанид хохирол учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээнэ гэж үздэг.

Компанийн хуулиас гадуур буюу дээр заасан хуулийн үндэслэлээр нөлөө бүхий этгээдэд хариуцлага хүлээлгэж болох эсэх нь эргэлзээтэй. Учир нь энэхүү хуулиуд нь зөвхөн албан ёсоор томилогдсон компанийн удирдлагуудад хамааралтай бөгөөд нөлөө бүхий этгээдийг томилогдсон захиралтай адилтгаж үзэж, шууд хариуцлага хүлээлгэх

боломжгүй. Нөлөө бүхий этгээдэд хариуцлага хүлээлгэсэн ихэнх шүүхийн шийдвэрүүд нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх биш, иргэний буюу хохирлыг нөхөн төлүүлэх, албан тушаалаас чөлөөлөх, эрхийг хасах зэрэг хариуцлагыг оногдуулсан байгаа нь үүнтэй холбоотой гэж үзэж болохоор байна.

2.1.3. Австрали улс дахь нөлөө бүхий этгээдийн хариуцлагын зохицуулалт

Австралийн (Corporations Act 2001)-ийн 9-р хэсгийн 9.b.ii-т “компанийн захирал биш боловч компанийн удирдлагууд түүний заавар, хүсэлтийн дагуу үйл ажиллагаа явуулж заншсан хүнийг удирдлагад тооцно” гэж сүүдрийн удирдлагыг тодорхойсон байдаг.

Австрали улсын компанийн хуулиар нөлөө бүхий этгээд нь албан ёсны удирдлагын адил үүргийг хүлээдэгээрээ Англи улстай төстэй байна. Тодруулбал, Corporations Act-д сүүдрийн удирдлагын нэршил дурдагдаагүй боловч хэрвээ 9.b.ii-т заасан шаардлагыг хангаж байгаа тохиолдолд тухайн этгээдийг шууд компанийн удирдлага гэж тооцохоор зохицуулсан байна. Энэ нь нөлөө бүхий этгээдийг хуульд заасан удирдлагад хамаарах үүргийг дагаж мөрдөх нөхцөлийг бүрдүүлж байна. Corporations act-ын 180-190-р зүйлүүдэд компанийн удирдлагад хамаарах үүргүүдийг заасан байдаг бөгөөд доор хүснэгтээр харуулав.

Хүснэгт 5. Австрали улсын компанийн хуулиар нөлөө бүхий этгээдийн хүлээх үүрэг

Corporations act 2001	Нөлөө бүхий этгээдийн хүлээх үүрэг (Genaral duties of director)
180	Анхааралтай, хичээл зүтгэлтэй ажиллах
181	Компанийн ашиг сонирхолыг тэргүүнд тавьж, санаачлагатай ажиллах
182	Өгөгдсөн үүргийн дагуу ажиллах
183	Өөрийн байр суурь болон мэдээллийг хувийн ашиг сонирхолдоо ашиглахгүй байх
184	Сонирхлын зөрчлийг мэдэгдэх
185	Төлбөрийн чадамжгүй болсон үед үйл ажиллагааг үргэлжлүүлэхээс зайлсхийх
187	Санхүүгийн бүртгэлийг зөв, цэгцтэй хөтлөх
188	Үндсэн хууль, дүрэм журмын дагуу үйл ажиллагаа явуулах

Эх сурвалж: Corporations act 2001, article 180-188

Дээрх үүрээс зөрчсөн тохиолдолд дараах хариуцлагын арга хэмжээг авахыг хуульчилжээ. Үүнд:

1. Торгууль ноогдуулах: Corporations act-ын 1317E хэсэгт 180-189-р хэсэгт заасан үүргээ зөрчвөл иргэний торгууль ноогдуулах тухай заасан.
2. Хохирлыг нөхөн төлүүлэх: Corporations act-ын 1317H хэсэгт шүүх нь удирдлагын буруугаас болж компанид учруулсан хохирлыг нөхөн төлөхийг шаардсан захирамж гаргаж болно.
3. Албан тушаалаас чөлөөлөх: Corporations act-ын 206C хэсэгт хэрэв үүргээ зөрчсөн тохиолдолд албан тушаалаас чөлөөлөх шийтгэл ноогдуулж болно.
4. Гэмт хэрэг: Хэрэв компанийн удирдлага эсвэл түүнд хамаарах этгээд нь үйл ажиллагаандаа хуурамч эсвэл үл зөвшөөрөгдсөн үйлдэл хийх юм уу, захиргааны үйл ажиллагаанд хууль бус үйлдэл гаргавал, түүнд гэмт хэрэгт холбогдох хариуцлага хүлээлгэнэ.

Дээрх жишгийн дагуу, компанийн нөлөө бүхий этгээд удирдлагад хамаарах үүргийг зөрчсөн тохиолдолд Австрали улсын жишгээр дараах байдлаар хариуцлага хүлээх боломжтой байна. Үүнд:

- Иргэний торгууль: 200,000 австрали доллар хүртэл.
- Хохирлыг нөхөн төлөх: Зөрчил гарсан улмаас компанид учирсан хохирлыг төлөх.
- Захирлаас татгалзах: 5 жил хүртэл захирлын албан тушаалаас татгалзах.
- Гэмт хэргийн торгууль (ноцтой зөрчилд): 5 жилийн хорих ял болон/эсвэл 220,000 австрали доллар торгууль.

2.2. Монгол улс дахь нөлөө бүхий этгээдэд хариуцлага оногдуулах тухай эрх зүйн орчин

2.2.1. Монгол улсад итгэлцлийн үүргээр сүүдрийн захиралд хариуцлага тооцох боломж

Монгол улсын хувьд дээрх онолын үүргүүд нь хууль зүйн томъёоллын хувьд компанийн эрх бүхий албан тушаалтны үүргийг тоочсон байдлаар илэрхийлэгддэг бөгөөд энэ үүргийг голчлон шүүх өөрөө агуулгыг нь тодорхойлох байдлаар зонхилох нөлөөтэй оролцдог байна.

Иймд Монгол улсын Компанийн тухай хуульд болон бусад хуулиудад тус онолын зарчмууд хэрхэн тусгагдсан байгааг доор харуулав.

Хүснэгт 6. Эрх бүхий албан тушаалтны хүлээх үүрэг (КтХ) болон итгэлцлийн үүргийн хамаарал

	Эрх бүхий албан тушаалтны үүрэг (КтХ 84.4)	КтХ 2011
Duty of Care - Хянамгай хандах үүрэг	Хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх	84.4.1
	Үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх	84.4.2
	Компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах	84.4.3
Duty of Loyalty - Үнэнчээр ажиллах үүрэг	Шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ тухайгаа тухай бүр мэдэгдэх	84.4.4
	Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хөндлөнгийн этгээдээс бэлэг, урамшуулал авахгүй байх	84.4.5
	Компанийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулах, хувийн сонирхлын зорилгоор ашиглахгүй байх	84.4.6

Эх сурвалж: Компанийн тухай хууль 2011

КтХ-д дээр дурдсан үүргүүдийг зөрчсөн тохиолдолд хүлээх хариуцлагыг 84.6, 84.9 болон 85.2 зүйлүүдэд тус тус зааж өгсөн бөгөөд “өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө” гэсэн байна.

Итгэл даах үүргээ гүйцэтгээгүй удирдлагын тод жишээ бол УИД ХК-ын хэрэгт холбогдох УИД-ийн ТУЗ мөн. УИД-ын ТУЗ-н сонирхлын зөрчилтэй гишүүд нь хараат бус гишүүдээс зөвшөөрөл авсаны үндсэн дээр холбогдох гэрээнүүдийг байгуулсан гэх бөгөөд хараат бус гишүүд зөвшөөрөл өгөхдөө үнэнч байх, хариуцлагатай байх хандах үүргээ ухамсарлаж шийдвэрийг гаргах ёстой байсан. Тодруулбал, гэрээ байгуулах зөвшөөрлийг өгсөн ТУЗ-н хараат бус гишүүд үнэнч байх, хариуцлагатай хандах үүргээ биелүүлсэн эсэхийг шалгахдаа гэрээний үнэ шударга байх ёстой, өөр гуравдагч этгээдтэй уг гэрээг байгуулсан бол энэхүү гэрээтэй адил нөхцөлөөр байгуулсан эсэхийг тогтоох ёстой байсан. Гэвч шүүхээс ТУЗ-д хамаарах үнэнч байх, хариуцлагатай байх үүргийн биелэлтийг огт хэлэлцээгүй байгаа нь Монгол улсын хувьд итгэл даах үүрэг (fiduciary

duty)-г зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх зарчим мөрдөгдөхгүй байна гэсэн дүгнэлтэд хүрч байна. СЗХ-оос УИД-н жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж тус компанийн нэр бүхий ТУЗ-н гишүүдийг хариуцагчаар татаж сонирхлын зөрчилтэй хэлцлийн маргаан буюу сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг хүчин төгөлдөр бусад тооцуулах маргааныг анхан шатны шүүхээс 2016 оны 2 дугаар сард шийдвэрлэсэн байх бөгөөд шүүхийн цахим хуудсанд маргааны төрлийн “бусад хуулиас” гэдэг төрөлд оруулан цахим хуудсанд тавигдсан байна.

Маргааны түүх

Монгол улсад анх удаа Санхүүгийн зохицуулах хороо өөрсдийн хуулиар олгогдсон эрх хэмжээний дагуу УИД ХК, Номин холдинг ХХК болон түүний охин компаниудын хооронд байгуулсан 13 гэрээг УИД-н барилгыг түрээсийн үнээс хэт доогуур түрээслэж байгаа, зах зээлийн үнээс өндөр үнээр Номин холдинг ХХК-с зээл авч УИД-н бие даасан байдлыг алдагдуулж, төлбөрийн чадваргүй болгож үнэ цэнийг бууруулж, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг зөрчсөн учир эдгээр гэрээнүүдийг КтХ-ийн 93-р зүйлд заасныг үндэслэн Иргэний хуулийн 56.1.8, 57-р зүйлийн дагуу хүчин төгөлдөр бусад тооцуулахаар жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргасан. Уг нэхэмжлэл анх Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд үүсэж 2016 оны 02 сарын 29-ны өдөр анхан шатны шүүхийн шийдвэр гарсан. УИД ХК-н ТУЗ-н дарга нь “Номин холдинг” ХХК-г эзэмшдэг бөгөөд бусад түрээсийн гэрээ байгуулсан “Номин реалтор” ХХК болон “Номин трейд” ХХК-н хувьцааг “Номин холдинг” ХХК болон ТУЗ-н нэг гишүүн, хувьцаа эзэмшигч нь хамтран эзэмшдэг байна.

УИД ХК нь 2014 оны санхүүгийн байдлаар 11 тэрбум төгрөгийн өртэй, 900 сая гаруй төгрөгийн эздийн өмч алдагдсан. СЗХ нь 2015 онд хоёр удаа тус компани дээр шалгалт оруулж

- 2006, 2008, 2009, 2010 онуудад гэрээ байгуулахдаа ТУЗ-н зөвшөөрөл аваагүй
- 2012, 2014 онуудад ТУЗ-н шийдвэрээр “Номин холдинг” ХХК-тай түрээсийн гэрээг байгуулах шийдвэр гаргасан байхад түрээсийн гэрээг “Номин реалтор” ХХК-тай байгуулсан. Энэхүү ТУЗ-н шийдвэр гаргасан хараат бус гишүүдийн мэдээлэл байхгүй байна. ТУЗ нь КтХ-н 84 дүгээр зүйлд заасан үүргээ зөрчиж гэрээ байгуулсан. Түрээсийн гэрээ байгуулсанаар УИД ХК хохирсон байхад “Номин холдинг” ХХК нь цааш дамжуулан түрээслэж зөвхөн 2014 он гэхэд л 3.5 тэрбум ашиг олсон нь санхүүгийн тайлангаар нь тогтоогддог.

Энэ мэтээр 13 гэрээний дагуу компанид хохирол учруулсан тухай нэхэмжлэлийг хариуцагч хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд байгуулсан бүх гэрээг зохих хууль ёсны дагуу байгуулагдсан гэж тайлбарласаар байсан.

Шүүхээс шийдвэрлэсэн байдал

Анхан шатны шүүхийн хуралдаанаас энэхүү 13 гэрээний 9 гэрээг байгуулахад ТУЗ-н хараат бус 2 гишүүн зөвшөөрөл олгосон. Үлдсэн 4 гэрээг 2012 онд шинээр томилогдсон хараат бус 3 гишүүний зөвшөөрлөөр хийсэн нь нотлох баримтаар тогтоогдож байх тул КтХ-н 93 дугаар зүйлийг зөрчөөгүй байна гэж дүгнэн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон.

Давж заалдах шатны шүүхээс хэргийн оролцогчийн эрх зүйн байдлыг зөв тодорхойлж чадаагүй, нэхэмжлэлийн шаардлага тодорхой бус байгаагаас шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагыг хангаагүй анхан шүүхээр нэхэмжлэгчийн эрх хэмжээг тодорхойлоогүй гуравдагч этгээдийг оруулагүй, ТУЗ хамтын удирдлага хэрэгжүүлдэг байтал иргэнийг хариуцагчаар татсан нь буруу гэж үзэн анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаасан.

Дүн шинжилгээ

Энэхүү хэргийн хариуцагчаар УИД ХК-н ТУЗ-н нэр бүхий сонирхлын зөрчилтэй этгээдүүдийг болон гүйцэтгэх захирлыг татсан. Гэтэл хэргийн гол асуудал болох сонирхлын зөрчилтэй гэрээнүүдийг байгуулах зөвшөөрлийг өгсөн этгээд нь байсан хараат бус ТУЗ-н гишүүд байсан учраас ТУЗ-г бүхэлд нь хаиуцагчаар татаж, ТУЗ-н хараат бус гишүүд нь хуульд заасан үүргээ биелүүлсэн эсэхийг шүүхээр шалгуулах нь зүйтэй байсан гэж дүгнэхээр байна. Давж заалдах шатны шүүхийн шийдвэрт энэ талаар дурдаагүй бөгөөд зөвхөн СЗХ-ны нэхэмжлэл гаргах эрхийн талаар л дурдсан байдаг. ТУЗ-ын хараааат бус гишүүд нь үүргээ зөрчсөн тухай тайлбарлаж, хариуцлага ноогдуулах боломж шүүхэд байсан бөгөөд зөвхөн КтХ-иар тогтохгүй иргэний хууль, компанийн дүрэм журам, ТУЗ-н гишүүдтэй байгуулсан гэрээнээс үүргийн биелэлтийг шалгаж үзэх боломжтой байсан.

Түүнчлэн КтХ-н 55-р зүйлд ТУЗ-н хараат бус гишүүд нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд зөвшөөрөл өгөхийн тулд давхар энэ хэлцлийн зах зээлийн үнийг тогтоож хэлцэл байгуулахад нь шийдвэрлэх үүрэгтэй оролцохыг зохицуулсан бөгөөд энэ үнийг хөндлөнгийн шинжээчээр тогтоолгож болно гэдгийг зохицуулсан байдаг.²⁹ Тиймээс

²⁹ КтХ (2011), 55.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн аль нэг гишүүн, эсхүл хэд хэдэн гишүүн, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн үнийг тогтоох шаардлагатай хэлцлийн нөгөө тал, эсхүл хэлцэлд зуучилж байгаа, уг хэлцлийн үр дүнд шууд болон шууд бусаар үүсэх

энэхүү хэргийн түрээсийн төлбөр болон зээлийн гэрээний хүүний асуудал дээр голлох үүргийг гүйцэтгэх этгээд нь ТУЗ-н гишүүд байсан бөгөөд тэд хуульд заасан үүргээ баримтлан зөв шийдвэрийг гаргах ёстой байсан. Гэтэл шүүхээс энэхүү асуудлыг орхигдуулсан байна.

2.2.2. Компанийн тухай хуулийн 9.4.

Дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигч болон компанийн үйл ажиллагааг бусад хэлбэрээр тодорхойлох эрх бүхий этгээдийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид учирсан эд хөрөнгийн хохирлыг тухайн этгээд өөрийн хөрөнгөөр компанийн өмнө хариуцна гэж компанийн тухай хуульд заасан байдаг.

КтХ-ийн 9.4-р зүйл нь нөлөө бүхий этгээдийн ойлголтод хамаарах эсэхийг шалгахын тулд судалгааны ажлын 1-р хэсэг буюу онолын хэсгийн “Сүүдрийн удирдлагад тооцох шалгуур” хэсэгт дурдсан Англи, Австраил улсын хуульд заасан тодорхойлолтын дагуу үнэлье.

Хүснэгт 7. КтХ-ийн 9.4-р зүйл нь нөлөө бүхий этгээдийн ойлголтод хамаарах эсэх

Англи улс	Австрали улс
<p>1. Тухайн этгээдийн зааварчилгаа эсвэл удирдамжын дагуу компанийн удирдлага “үйл ажиллагаа явуулсан байх”</p> <p>2. Удирдлагууд зааварчилгаа, удирдамжийн дагуу үйл ажиллагаа явуулахад "заншсан, сурсан, дассан" байх</p>	<p>3. Компанийн албан ёсны захирал биш байх</p> <p>4. Удирдлагууд заавар, хүсэлтийн дагуу үйл ажиллагаа явуулж заншсан буюу дассан байх (2-т заасан нөхцөлтэй давхацсан)</p>
<p>Дээрх нөхцөл бүрдэх боломжтой байна. Учир нь 10-аас дээш хувийн хувьцааг эзэмшиж байгаа нь компанийн удирдлагын шийдвэр гаргалтанд нөлөөлөхүйц эрх мэдэлтэй этгээд гэж үзнэ. Мөн КтХ-ийн 9.4-т компанийн үйл ажиллагааг бусад хэлбэрээр тодорхойлох эрх бүхий этгээд гэж дурдсан байгаа</p>	<p>Дээрх нөхцөлийг хангах боломжтой байна. Захирлын албанд томилогдоогүй ч ТУЗ-ын үйл ажиллагаанд нөлөөлж чаддаг бол сүүдрийн захирал гэж тооцогдох боломжтой.</p>

орлогоос хувь хүртэж байгаа тохиолдолд зах зээлийн үнийг уг хэлцлийг байгуулах талаар сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

<p>учраас тодорхой хэмжээний эрх мэдлээр сүүдрийн удирдлагыг хэрэгжүүлэх боломжтой харагдаж байна.</p>	
--	--

Эх сурвалж: Companies act 2006, Corporations act 2001, Компанийн тухай хууль 2011

Зарим тохиолдолд том хувьцаа эзэмшигч (жишээ нь 10%-иас дээш хувьцаа эзэмшигч) компанийн үйл ажиллагаанд их хэмжээний нөлөө үзүүлж чаддаг. Ялангуяа, нийт хувьцаа эзэмшигчид эсвэл захирлуудтай ойр хамтран ажилладаг бол сүүдрийн захирал гэж тооцож болох юм. Мэдээж, 10%-иас дээш хувьцааг эзэмшигч нь шууд нөлөө бүхий этгээд болж хувирахгүй. ТУЗ-ын шийдвэрт нөлөө үзүүлж байгаа гэдэг нь баттай нотлогдсон байх хэрэгтэй. Жишээ нь, хэрэв хувьцаа эзэмшигч нь удирдлагад тогтмол зааварчилгаа өгч, компанийн стратеги, шийдвэрүүдийг захирлуудад зааварлан удирддаг бөгөөд удирдлагаас түүнийг даган ажилладаг бол, тэр хувьцаа эзэмшигч нь сүүдрийн захирал болох боломжтой.

Харин хувьцаа эзэмшигч нь зөвхөн хувьцаа эзэмшигчийн эрхээ ашиглаж, саналаа илэрхийлэх байдлаар заавар зөвлөмж өгч байгаа бол, түүнийг сүүдрийн захирал гэж үзэхгүй.

2.2.3. Компанийн тухай хуулийн 84-р зүйлийн 84.10

“Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн нийт гаргасан хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг этгээд нь энэ хуулийн 84 дүгээр зүйлд заасан хариуцлагыг эрх бүхий албан тушаалтны нэгэн адил хүлээнэ.” хэмээн заасан байдаг. КтХ-ийн 9.4-г заасан хувьцаа эзэмшигч сүүдрийн удирдлага байх боломжтой гэж дурдсантай ижил байдлаар 20% буюу түүнээс дээш хувийг хувьцааг нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг этгээд нь сүүдрийн удирдлага байх боломжтой гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Монгол улсын хувьд де-факто удирдлагад хариуцлага тооцсон тохиолдол байдаг бөгөөд ийнхүү хариуцлага тооцохдоо Компанийн тухай хуулийн 84-р зүйлийн 84.10-аар зүйчилсэн байдаг. Шүүхийн шийдвэрийг тодруулбал:

Нийслэлийн давж заалдах шатны шүүх хуралдааны бүрэлдэхүүний 2021 оны 08 сарын 27 өдрийн 210/МА2021/01314 дугаартай магадлал

Хэргийн агуулга

"Д" ХХК нь "С" ХХК-тай байгуулсан 2019.6.27-ны өдөр 19/03 дугаартай "Бетон зуурмагийн нэмэлт бодис худалдах, худалдан авах гэрээ" байгуулсан ба гэрээний дагуу

хугацаа хэтрүүлсний төлбөрийн алдангийг нэхэмжилсэн. Үүний хариуд "С" ХХК-аас тус гэрээний тал нь "С" ХХК бус, түүний хувьцаа эзэмшигч Ж.Ж тул нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгохыг хүссэн байна.

Үйл баримтын хүрээнд:

1) Гэрээнд худалдагч "Д" ХХК-ийг төлөөлж захирал G.D.D, менежер Т.Т нар, худалдан авагч "С" ХХК-ийг төлөөлж захирал Ж.Ж нар гарын үсэг зурж хариуцагч компанийн тамга дарагдсан байна.

2) Хариуцагч "С" ХХК-ийн улсын бүртгэлийн лавлагаа, дүрмээс харахад Ж.Ж, Б.Б нар тус бүр компанийн нийт хувьцааны 50 хувийг эзэмшдэг, захирал нь Б.Б болох нь тогтоогдсон.

3) Хэдийгээр гэрээнд гарын үсэг зурсан Ж.Ж хариуцагч компанийн захирал биш боловч гэрээ бодитоор хэрэгжсэн, нэхэмжлэгч нь хариуцагч "С" ХХК-д 1 тонн нь 2,600,000 төгрөгийн үнэтэй, 14 тонн, нийт 36,400,000 төгрөгийн үнэ бүхий DF-100, DF-101 маркийн бетон зуурмагийн нэмэлт бодис нийлүүлсэн, харин хариуцагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй болох нь нэхэмжлэгчийн тайлбар, хэрэгт авагдсан баримтуудаар тогтоогдож байна.

Нэхэмжлэгчтэй байгуулсан гэрээ, хооронд харилцаж байсан албан бичигт гүйцэтгэх захирал Ж.Ж гэсэн байх бөгөөд тэрээр компанийн хувьцаа эзэмшигч буюу компанийг төлөөлж гэрээ хийх, тайлбар гаргах эрх бүхий этгээд биш юм. Компанийн гэрчилгээнд захирлаар Б.Б-г томилсон нь бүртгэгдсэн. Компанийг төлөөлөх эрхгүй этгээд гуравдагч этгээдтэй хэлцэл хийсэн тул уг хэлцэл хүчин төгөлдөр байх эсэх нь төлөөлүүлсэн этгээдийн зөвшөөрлөөс шалтгаална. Иймд анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож өгнө үү гэжээ. Хэрэгт авагдсан баримтаар "С" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээнд Б.Б-г захирлаар бүртгэсэн боловч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаагаар Ж.Ж, Б.Б нар гэр бүлийн гишүүд, тус компанийн хувьцааг тавь тавин хувиар(КТХ 84.10) эзэмшдэг болох нь тогтоогдож байна.

Иймээс (КТх 84.10) дахь хэсэгт зааснаар хязгаарлагдмал хариуцлагатай компанийн энгийн хувьцааны 20 ба түүнээс дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувь нийлүүлэгчийг энэ хуулийн (84.10) -д заасан эрх бүхий албан тушаалтантай адилтгаж үзэх боломжтой. Дээрх үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн давж заалдах гомдлыг ханахгүй орхих нь зүйтэй гэж давж заалдах шатны шүүх бүрэлдэхүүн дүгнэсэн.

Дүн шинжилгээ

Уг шүүхийн шийдвэр нь компанийн гүйцэтгэх удирдлага биш боловч хувьцаа эзэмших байдлаар удирдлагыг хэрэгжүүлж буй этгээдийг гүйцэтгэх удирдлагатай адилтган үзэх замаар буюу бодит байдал дээрх гүйцэтгэх удирдлагад тооцож, гэрээний харилцаа компанитай үүссэн хэмээн үзсэн байна.

Ийнхүү доод шатны шүүхийн практикт том хувьцаа эзэмшигчийг эрх бүхий албан тушаалтантай адилтгасан зохицуулалтыг хэрэглэх замаар де факто гүйцэтгэх удирдлагыг хүлээн зөвшөөрсөн шийдвэрийг гаргасан тохиолдолд бий.

2.2.4. Эрх бүхий албан тушаалтаны адилаар хариуцлага хүлээлгэх

Англи, Австрали улсын жишгээр нөлөө бүхий этгээд нь албан ёсоор томилогдсон захирал, ТУЗ, бусад компанийн удирдлагад хамаарах этгээдийн нэгэн адилаар үүргийг хүлээдэг. Монгол улсын хувьд дээрх этгээдүүд нь “эрх бүхий албан тушаалтан” гэсэн нэр томъёонд хамаарч байна. КтХ-ийн 84-р зүйлийн 84.1-т компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцохоор заасан байдаг.

КтХ-д эрх бүхий этгээд нь хэрвээ хуульд заасан үүргээ зөрчсөн тохиолдолд компанид учирсан хохирлыг өөрийн хөрөнгөөр төлөхөөр зохицуулсан байна. Тодруулбал, КтХ-ийн 85-р зүйлийн 85.2, 84-р зүйлийн 84.6, 84.9-т тус тус ийнхүү заажээ. Хүснэгт 8. *КтХ-д заасан эрх бүхий албан тушаалтны хариуцлага*

Эрх бүхий албан тушаалтны хариуцлага	КтХ 2011
Компанийн эрх бүхий албан тушаалтан нь энэ хуулийн 84.4, 84.5-д заасан үүргээ биелүүлээгүй, удаа дараа зөрчсөнөөс компанид хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.	84.6
Энэ хуулийн 84.4-т заасныг зөрчин шийдвэр гаргасан албан тушаалтнууд хамтын хариуцлага хүлээх бөгөөд хохирлыг тэнцүү хэмжээгээр нөхөн төлнө.	84.9
Компанийн эрх бүхий албан тушаалтан дор дурдсан хууль бус үйлдэл, эс үйлдлийн улмаас компани, хувьцаа эзэмшигч болон зээлдүүлэгчид учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.	85.2

Компанийн эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 85.2.5-д заасан эс үйлдлийг хийсэн бол мэдээллийг хугацаандаа аваагүйгээс тухайн этгээдэд учирсан хохирлыг нөхөн төлнө.	85.3
Өөрийн буруугаас компанид хохирол учруулсан эрх бүхий албан тушаалтанд холбогдох хуульд заасан хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр энэ хуулийн 85 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэж болно.	85.4

Эх сурвалж: Компанийн тухай хууль 2011

85 дугаар зүйл. Компанийн эрх бүхий албан тушаалтны хүлээх хариуцлага

85.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан дор дурдсан хууль бус үйлдэл, эс үйлдлийн улмаас компани, хувьцаа эзэмшигч болон зээлдүүлэгчид учруулсан хохирлыг **өөрийн хөрөнгөөр** нөхөн төлнө:

85.2.1. компанийн нэрийг хувийн сонирхлоор ашигласан;

85.2.2. хувьцаа эзэмшигч болон зээлдүүлэгчид санаатайгаар хуурамч мэдээлэл өгсөн;

85.2.3. мэдээлэл өгөх үүргээ биелүүлээгүй;

85.2.4. энэ хуулийн 97 дугаар зүйлд заасан компанийн баримт бичгийг зохих журмын дагуу хадгалаагүй;

85.2.5. энэ хуулийн 98 дугаар зүйлд заасан мэдээллийг мэдээлэл авах эрх бүхий этгээдэд гаргаж өгөөгүй, хугацаа хожимдуулан гаргаж өгсөн.

2.3 Гадаад болон Монгол улсын нөлөө бүхий этгээдийн эрх зүйн зохицуулалтын харьцуулалт

а. Нөлөө бүхий этгээдийг хууль журмандаа хэрхэн тодорхойлж байгаагаар

Английн компанийн хуулийн дагуу нөлөө бүхий этгээд болон албан ёсны удирдлагыг ялгамжтай байдлаар тодорхойлж зохицуулсан байдаг. Харин Австралийн компанийн хууль нь нөлөө бүхий этгээд болон компанийн албан ёсны удирдлагын аль алиныг “захирлууд” хэмээх өргөжүүлсэн ойлголтод багтааж тодорхойлсон байдаг. Мөн Австралийн компанийн де факто эсвэл сүүдрийн захирал нь дараах үүргүүдийг гүйцэтгэхэд "захирал" хэмээх ойлголтод хамаарахгүй:

- Компаниудын гишүүдийн хуралд дуудлага хийх эрх (Corp act 249C),
- Хурлын тэмдэглэлийг гарын үсэг зурах (Corp act 251A(3)),
- Австралийн Үнэт Цаасны ба Хөрөнгө Оруулалтын Комисс (ASIC)-д хаягийн өөрчлөлт мэдэгдэх (Corp act 205B).

Хүснэгт 9. Англи, Австрали, Монгол улсын сүүдрийн захирлыг хуулиар тодорхойлсон байдлын харьцуулалт

	Англи улс	Австрали улс	Монгол улс
Зохицуулж буй хууль	Companies act 2006	Corporations acts 2001	КтХ 2011
Сүүдрийн удирдлагыг тодорхойлсон байдал	Английн (Companies Act 2006)-ийн 251-р зүйлийн нэг дэх хэсэгт “компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор компанийн удирдлагад зааварчилгаа өгөх байдлаар нөлөөлж заншсан этгээдийг хэлнэ” гэсэн нөхцөлөөр тодорхойлсон байна.	Австралийн (Corporations Act 2001)-ийн 9-р хэсгийн 9.b.ii-г “компанийн захирал биш боловч компанийн удирдлагууд түүний заавар, хүсэлтийн дагуу үйл ажиллагаа явуулж заншсан хүнийг удирдлагад тооцно” гэж заасан.	Тодорхойлолт байхгүй.
Сүүдрийн удирдлага нь албан ёсоор томилогдсон захирлын нэгэн адил үүрэг хүлээдэг эсэх	Тийм	Тийм	Хэрэв эрх бүхий албан тушаалтанд хамаарна гэж үзвэл “Тийм”

Эх сурвалж: Companies act 2006, Corporations acts 2001, КтХ 2011

Мөн Англи, Австрали улсууд сүүдрийн удирдлагыг тодорхойлохоос гадна сүүдрийн удирдлагад хамаарахгүй нөхцөлүүдийг тодорхой заасан байдаг. Англи болон Австрали улс нь мэргэжлийн зөвлөхүүдийг нөлөө бүхий этгээд гэж тооцохоос сэргийлсэн заалтыг оруулж өгсөн байдлаараа хоорондоо төсөөтэй боловч Англи улс нь зөвхөн мэргэжлийн зөвлөхүүдээс гадна толгой болон охин компани, бусад нэр бүхий этгээдүүдийг нөлөө бүхий этгээд гэж үзэхгүй тухай компанийн хуулиндаа зааж өгсөнөөрөө бусад улсыг бодвол илүү нарийвчлан зохицуулсан гэж үзэж болохоор байна.

б. Нөлөө бүхий этгээдэд хамаарах үүргээр

Итгэл даах үүрэг(fiduciary duty) нь Англи, Австрали, Монгол улсуудын компанийн тухай хуулиудын компанийн удирдлагын хүлээх үүрийг заасан хэсэгт агуулгаараа тусгагдаж өгсөн байдлаараа төстэй байна. Тодруулбал, Англи улсын хувьд, компанийн хуулийн 170(5)-р хэсэг-ийн дагуу нөлөө бүхий этгээдийг ерөнхий удирдлагын нэгэн адил хүлээхээр заасн байдаг бөгөөд нөлөө бүхий этгээдийн хүлээх үүргийг тухай Хүснэгт4-т харуулсан байгаа. Энэхүү үүргүүд нь итгэл даах үүргийн шинжийг агуулсан болно.

Австрали улсын хувьд мөн адил Corporations act-ын 180-190-р зүйлүүдэд компанийн удирдлагад хамаарах үүргүүдийг заасан байдаг бөгөөд эдгээр үүргүүдийг нөлөө бүхий этгээд мөн адил хүлээх тухай Хүснэгт5-д харуулсан байгаа.

Монгол улсын хувьд компанийн тухай хуулийн 84-р зүйлд заасан эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэх үүргийн зохицуулалт нь энэхүү онолын ойлголтод хамгийн дөхөм байна. КтХ-н 84.4-д заасан эрх бүхий албан тушаалтны үүргүүд нь мөн итгэл даах үүргийн шинжийг агуулж байгаа бөгөөд энэ тухай Хүснэгт6-д тайлбарласан байгаа.

в. Нөлөө бүхий этгээдэд хүлээлгэх хариуцлага

Нөлөө бүхий этгээдүүд нь компанийн тухай хуульд заасан ерөнхий үүргийг зөрчсөн тохиолдолд хүлээх хариуцлага нь Англи, Австрали, Монгол улсын хувьд харьцангуй ялгаатай байна.

Англи улсын хувьд хуульд заасан ерөнхий үүргийг зөрчсөн тохиолдолд дараах хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

1. Компанид учирсан хохирол алдагдлыг нөхөн төлүүлэх
2. Албан тушаалаас чөлөөлөх, эрхийг хасах
3. Компани эсвэл хувьцаа эзэмшигчид захирлын үүргээ биелүүлэхийг шаардах шүүхийн шийдвэр гаргуулах арга хэмжээг авдаг бөгөөд удирдлагын компанид учирсан хохирлыг ноцтой гэж үзвэл компанийн хуульд заасан хариуцлагаас гадна “Company Directors Disqualification Act 1986”, “Fraud Act 2006” зэрэг эрх зүйн актуудаар эрүүгийн хэрэгт татах боломжтой байдаг.

Австрали улсын хувьд үүргээ зөрчсөн тохиолдолд дараах хариуцлагын арга хэмжээг авахыг хуульчилсан. Үүнд:

1. Торгууль ноогдуулах: Corporations act-ын 1317E хэсэгт 180-189-р хэсэгт заасан үүргээ зөрчвөл иргэний торгууль ноогдуулах тухай заасан. (200,000 австрали доллар хүртэл.)
2. Хохирлыг нөхөн төлүүлэх: Corporations act-ын 1317H хэсэгт шүүх нь удирдлагын буруугаас болж компанид учруулсан хохирлыг нөхөн төлөхийг шаардсан захирамж гаргаж болно.
3. Албан тушаалаас чөлөөлөх: Corporations act-ын 206C хэсэгт хэрэв үүргээ зөрчсөн тохиолдолд албан тушаалаас чөлөөлөх шийтгэл ноогдуулж болно.
4. Эрүүгийн хариуцлага: Хэрэв компанийн удирдлага эсвэл түүнд хамаарах этгээд нь үйл ажиллагаандаа хуурамч эсвэл үл зөвшөөрөгдсөн үйлдэл хийх юм уу, захиргааны үйл ажиллагаанд хууль бус үйлдэл гаргавал, түүнд гэмт хэрэгт холбогдох хариуцлага хүлээлгэнэ.

Монгол улсын хувьд КтХ-д заасан эрх бүхий албан тушаалтны үүргийг зөрчсөн гэж үзэж КтХ-ийн 85-р зүйлийн 85.2, 84- р зүйлийн 84.6, 84.9-т заасны дагуу хариуцлага хүлээлгэх буюу учирсан хохирлыг нөхөн төлүүлэх байдлаар хариуцлага хүлээлгэх боломжтой гэж үзэж байгаа нь Англи, Австрали улстай харьцуулахад илүү хязгаарлагдмал байна гэж ажиглагдаж байна.

Манай улсын хувьд сүүдрийн удирдлага гэсэн тодорхойлолт байхгүй бөгөөд нөлөө бүхий этгээд гэхээсээ илүү наад зах нь компанийн албан ёсны удирдлага буюу эрх бүхий албан тушаалтны хуулиар хүлээсэн үүргийн зөрчилд хариуцлага хүлээлгэж чадахгүй байгаа нөхцөлийг УИД ХК-н ТУЗ-ийн жишээн дээрээс харж болохоор байна. Зөвхөн албан ёсны удирдлагын үүргийн зөрчилд хариуцлага тооцох асуудал нь шүүхэд ялгамжтай гарч байгаа тохиолдолд албан ёсны удирдлагад хамаарахгүй боловч удирдлагын шийдвэр гаргалтад нөлөөлсөн нөлөө бүхий этгээдийг “эрх бүхий албан тушаалтан”-тай адилтгаж хариуцлага хүлээлгэх боломж нь Англи, Австрали улстай харьцуулахад бүр ч илүү бүрхэг, бэрхшээлтэй байж болзошгүй харагдаж байна.

ДҮГНЭЛТ

Судалгааны сэдвийн хүрээнд “компанийн нөлөө бүхий этгээд” гэж хэн болох, хуулиар зохицуулагдсан эсэх, ямар үүрэг хариуцлагыг хүлээх ёстой талаар тодруулан МУ-д энэхүү онолын ойлголтыг хэрхэн тайлбарлаж, эрх зүйн хүрээнд зохицуулж болох талаар гадаад орны эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалсны үндсэн дээр дараах дүгнэлтэнд хүрлээ.

1. Сүүдрийн удирдлага буюу нөлөө бүхий этгээд нь зөвхөн хуулиар зохицуулагдсан улс орнуудад хамаарах ойлголт биш бөгөөд Монгол улсын хувьд ч мөн адил том хувьцаа эзэмшигч өөрөө гүйцэтгэх удирдлага биш боловч, компанийг төлөөлөн гэрээ хэлцэл хийсэн тохиолдолд, эсхүл улсын бүртгэл дээр тодорхой этгээдийг гүйцэтгэх удирдлагаар бүртгүүлсэн боловч, бодит байдал дээр аль нэг хувьцаа эзэмшигч компанийг удирдаж байх тохиолдол, түүнчлэн ТӨК-ийн ТУЗ-д төрийг төлөөлж буй тохиолдолд, эсхүл толгой болон охин компанийн харилцаанд нөлөө бүхий этгээд үүсэх нөхцөл бий болдог.
2. Манай улсын компанийн тухай хуулийн 84-р зүйлд заасан эрх бүхий этгээдийн итгэл даах, үнэнчээр ажиллах үүрэг буюу компанийн эрх ашгийг дээдэлж үнэнчээр ажиллах зарчим, компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах хянамгай байдлын зарчмуудын дагуу эдгээр үүргээ биелүүлээгүй тохиолдолд компанид хохирол учирсан тохиолдолд хохирлыг нөхөн төлүүлэхээр зохицуулсан ч шүүхээс эрх бүхий албан тушаалтныг уг үүргээ биелүүлсэн эсэхийг хэрхэн тогтоох талаар тодорхойгүй байдалтай байна.
3. ТӨК-ийн жишээн дээр, төрийн төлөөллийг хэрэгжүүлэх тухай “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам, 2023” байдаг боловч журамд төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч этгээдийг сонгон шалгаруулах журмыг мэргэжлийн ур чадварын үүднээс нарийвчлан тодорхойлоогүй байдаг. Ийхүү тэдгээр мэргэшсэн байх шалгуур хангаагүй хүмүүсээр ТУЗ-ийг бүрдүүлэх тухайн төлөөлөгч шийдвэр гаргахдаа ТӨХЭ-ийн ашиг сонирхлоос илүү өөрийг нь томилсон албан тушаалтны ашиг сонирхлыг илүүд үздэг буюу нэг үгээр хэлбэл нөлөө бүхий этгээд бий болох магадлалыг нэмэгдүүлж байна.

САНАЛ ЗӨВЛӨМЖ

1. Нөлөө бүхий этгээдийн талаар албан ёсны тайлбарыг гаргах
2. Компанийн эрх бүхий этгээдийн хуульд заасан үүргүүд болон үнэнчээр ажиллах, хянамгай ажиллах үүргүүдийг биелүүлсэн эсэхийг тогтооход баримтлах шаардлага, шалгуурыг хуульд тодорхой болгох
3. Компанийн эрх бүхий албан тушаалтны тодорхойлолтын хүрээг нэмэгдүүлэх буюу нөлөө бүхий этгээдийг шинжийг агуулсан “албан ёсны ажилтан биш байх, удирдлагад хамаарахгүй байх” зэрэг шинжийг агуулсан этгээдийг хамааруулахаар нэмэх
4. Компанийн тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтны үүргийн зөрчилд хүлээлгэх хариуцлагын төрлийг нэмэгдүүлэх буюу олсон орлогыг хураах, тодорхой албан тушаал эрхлэх эрхийг хасах байдлаар хариуцлагын зохицуулалтыг компанийн тухай хуулиар нэмж зохицуулах
5. ТӨК-ийн ТУЗ-д төрөөс төлөөлөх этгээдэд тавигдах мэргэшил, ур чадварын тусгай шаардлагыг бүрэн хангахын тулд нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах үйл ажиллагааг ур чадварын зарчимд суурилан зохион байгуулах механизм бүрдүүлэх, журам батлах
6. УИХ-ын гишүүн, сайд, төрийн нарийн бичгийн дарга нарыг өөрийн шууд харьяаллын ТӨХЭ-ийн ТУЗ-д ажиллахыг хориглох

НОМ ЗҮЙ

Монгол хэл дээрх:

- 1.Амарсанаа, Б. (2012), *Компанийн засаглал, компанийн эрх зүйн тулгамдсан асуудал*, УБ
- 2.Давааням, Г.; Түвшинжаргал, М.; (2022); *Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн төлөөлөн удирдах зөвлөл: Олон Улсын Туршлага ба Монгол Улс Уул уурхайн салбарын жишээн дээр, Нээлттэй Нийгэм Форум*
- 3.*Иргэний хууль 2002*
- 4.*Компанийн тухай хууль 2011*
- 5.Коннел Фионна, Цогт, Н. (2008), *Компанийн эрх зүй, сургалтын гарын авлага*, УБ
- 6.*Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан.* (n.d.). <https://shuukh.mn/>
- 7.Очи-Ай Сэйчи, (2017), *Компанийн эрх зүйн үндсэн ойлголт (Япон орчуулгын бүтээл)*, УБ
- 8.*Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам 2023*
- 9.Түвшинжаргал, М., Бодьбилиг, А; (2023) *Төрийн өмчит компанийн ТУЗ-ийн бүрэн эрх ба хариуцлага*, Нээлттэй нийгэм форум, Улаанбаатар
- 10.*Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагийн Компанийн засаглалын зарчмууд*, (G20/OECD, 2015)
- 11.*Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.* (n.d.). Эрх Зүйн Мэдээллийн Нэгдсэн Систем. <https://legalinfo.mn/>

Гадаад хэл дээрх:

- 1.*Academia.edu - Find research papers, topics, researchers.* (n.d.). Academia.edu. <https://www.academia.edu/>
- 2.Companies act 2006
- 3.Company Directors Disqualification Act 1986
- 4.Corporations act 2001
- 5.David Green, *Understanding Shadow Directors: Liability and Fiduciary Duties* (Oxford: Oxford University Press, 2020), 120-135.
- 6.Explore the world's knowledge, cultures, and ideas. (n.d.). JSTOR. <https://www.jstor.org/>
- 7.*Google Scholar.* (n.d.). <https://scholar.google.com/>
- 8.Insolvency Act 1986
- 9.John Doe, *Obligations in the Shade: The Application of Fiduciary Directors' Duties to Shadow* (University of Kent, 2016)
- 10.John Doe, *Obligations in the Shade: The Application of Fiduciary Directors' Duties to Shadow Directors* (University of Kent, 2016)
Холбоос:https://download.ssrn.com/23/05/02/ssrn_id4414582_code1564444.pdf.

11. Michael White, *Exploring Fiduciary Duty: The Role of Shadow Directors in Corporate Law* (2015), https://www.lawjournals.org/ssrn_id2448316.
12. *Obligations in the Shade: The Application of Fiduciary Directors' Duties to Shadow Directors at SLS Conference 2014, Nottingham* (Academia.edu, 2014),
13. Robert Brown, *Shadow Directors in Corporate Governance: The Role of Fiduciary Duties* (2017), <https://www.jstor.org/stable/4093011>.
14. Samantha Black, *The Shadow Director Doctrine and Its Impact on Corporate Law* (New York: Routledge, 2016), 76-90.
15. William Jones, *Shadow Directors and Fiduciary Duties: A Modern Perspective* (2014), Холбоос: https://www.researchgate.net/publication/291010659_Shadow_Directors_and_Fiduciary_Duties_A_Modern_Perspective.

ТӨГСӨВ

ХАВСРАЛТ1

ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ТӨРИЙН ӨМЧИЙН ТӨЛӨӨЛӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж, төрийн өмчийн төлөөлөгчийг томилох, сонгон шалгаруулах, түүнд тавих шаардлага, хэрэгжүүлэх эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино.

1.2. Энэ журмын зохицуулалтад төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой дараах хуулийн этгээд (цаашид "төрийн өмчит компани" гэх) хамаарна:

1.2.1.нийт гаргасан энгийн хувьцааг нь 100 хувь төр эзэмшдэг төрийн өмчийн компани;

1.2.2.нийт гаргасан энгийн хувьцааны 34-өөс 100 хүртэл хувийг нь төр эзэмшдэг төрийн өмчийн оролцоотой компани.

1.3.Төрийн өмчит компанийн хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг тухайн компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд томилогдсон төрийн өмчийн төлөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлнэ

Хоёр.Төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн чиг үүрэг

2.1.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасны дагуу Засгийн газраас тогтоосон төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч (цаашид "хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч" гэх) төрийн өмчийн төлөөллийн талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1.төрийн өмчийн оролцоотой компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох төрийн өмчийн төлөөлөгчийг томилох;

2.1.2.энэ журмын 2.1.1-д заасан этгээдэд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал бүрээр өгөх саналд удирдамж, чиглэл өгөх, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хэлэлцэх асуудлын талаар зохих журмын дагуу хувьцаа эзэмшигчээс тодорхой чиглэл авах;

2.1.3.төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн эзэмшлийн хувьцааны хэмжээнд тохирох тооны гишүүн (цаашид "төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн" гэх)-ийг томилох, чөлөөлөх, эсхүл томилох, чөлөөлөх саналыг хувьцаа эзэмшигчдийн хуралд хүргүүлэх;

2.1.4.энэ журмын 2.1.3-т заасан этгээдээр дамжуулан төрийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хүрээнд хамаарах асуудлаар санал оруулах, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хувьцаа эзэмшигчээс тодорхой чиглэл авах;

2.1.5.төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг зохион байгуулах.

2.2.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч доор дурдсан чиглэлээр энэ журмын 2.1.1, 2.1.3-т заасан этгээдэд удирдамж өгнө:

2.2.1.компанийн тухайн жилийн бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, төсвийг батлах;

2.2.2.компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох;

2.2.3.компанийн тухайн жилийн үйл ажиллагааны болон санхүү, аудитын тайланг хэлэлцэж, дүгнэлт гаргах;

2.2.4.ногдол ашгийг хэмжээг тогтоох, нэмэгдүүлэх;

2.2.5.бизнесийн тодорхой төсөл, томоохон хөрөнгө оруулалтын арга хэмжээ санхүүжүүлэх, хэрэгжүүлэх;

2.2.6.зээл авах, хувьцаа, үнэт цаас гаргахтай холбогдсон шийдвэр гаргах;

2.2.7.их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

2.2.8.компанийн үйл ажиллагаа, санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг хэмнэх, эрсдэлийг бууруулах, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх;

2.2.9.компанийн дүрэмд тухайлан заасан бусад.

2.3.Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийг шинээр байгуулах, эсхүл төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сул орон тоо гарсан бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг томилох, сонгон шалгаруулахад энэ журмыг баримтална.

2.4.Энэ журмын 2.1.1, 2.1.3-т заасан этгээдийн ажлын гүйцэтгэл, төлөөлөл хэрэгжүүлсэн байдлыг үнэлэх, дүгнэх нийтлэг журмыг төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

2.5.Хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь энэ журмын 2.4-т заасан нийтлэг журмыг баримтлан төрийн өмчийн төлөөлөгчийн ажлын гүйцэтгэл, үйл ажиллагааны тайланг үнэлж, дүгнэлт гаргана.

2.6.Эрчим хүчний салбарын төрийн өмчит компанийн нийт хувьцааны 66 хувийн төлөөллийг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 34 хувийн төлөөллийг төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус тус хэрэгжүүлнэ.

2.7."Тавантолгой түлш" ХХК-ийн нийт хувьцааны 51 хувийн төлөөллийг "Эрдэнэс-Тавантолгой" ХК, 39 хувийн төлөөллийг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 10 хувийн төлөөллийг төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус тус хэрэгжүүлнэ.

2.8."Оюутолгой" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх этгээдийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас чиглэл болгосны дагуу "Эрдэнэс Монгол" ХХК нэр дэвшүүлж, "Оюутолгой" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал томилж, чөлөөлнө.

Гурав.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд тавих шаардлага

3.1.Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан болзлоос гадна дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

3.1.1.Эрүүгийн хуульд заасан эдийн засгийн, авлигын, өмчийн эсрэг гэмт хэрэгт шүүхийн шийдвэрээр гэм буруутай нь тогтоогдож байгаагүй байх;

3.1.2.нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, компанийн зорилго, ашиг сонирхолд нийцүүлэн ажиллах чадвартай;

3.1.3.сүүлийн дөрвөн жил улс төрийн намын ажилтан, сонгуульт удирдах албан тушаал хашиж байгаагүй, эсхүл улс төрийн албан хаагчаар ажиллаж байгаагүй;

3.1.4.эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан хуулийн этгээд нь дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь түүнээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон;

3.1.5.эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон нь түүнээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон;

3.1.6.компанийн засаглал болон чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой бусад мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх;

3.1.7.төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй байх.

3.2.Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд тавигдах мэргэжил, мэргэшил, боловсрол, ур чадвар, ажлын туршлагын талаарх тусгай шаардлагыг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч болон төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэх хороо тухайн компанийн үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, онцлог нөхцөл байдлыг харгалзан тодорхойлно.

3.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь доор дурдсан ашиг сонирхлын зөрчилтэй этгээд биш байна:

3.3.1.тухайн компанитай адил салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компанийн хувьцаа эзэмшигч, эсхүл хувьцааны хяналтын багцыг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшигч;

3.3.2.тухайн компанитай адил салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн;

3.3.3.төрийн өмчит компанийн ажил, үйлчилгээг хүлээн авах, бараа бүтээгдэхүүнийг худалдан авах, эсхүл тус компанид ажил, үйлчилгээ үзүүлэх, бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, худалдах үйл ажиллагаа явуулах зэрэг байдлаар компанитай харилцах замаар их хэмжээний хэлцэл байгуулсан аливаа этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн;

3.3.4.хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч удирдах албан тушаалтантай хамаарал бүхий, эсхүл нэгдмэл сонирхолтой.

Дөрөв.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх

4.1.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн төрийг төлөөлөх нийт гишүүний гуравны хоёроос доошгүй хувийг сонгон шалгаруулж томилно.

4.2.Төрийн өмчийн оролцоотой компанийн хувьд төрийн эзэмшлийн хувьцаатай хувь тэнцүүлэн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд санал болгоно.

4.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг албан тушаалаар нь томилохгүй.

4.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд хяналт шалгалтын байгууллагын төлөөлөл болон тухайн компанийн гүйцэтгэх удирдлагыг томилохгүй.

4.5.Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жилээс хэтрэхгүй байх бөгөөд ажлын гүйцэтгэл, үйл ажиллагааны тайланг үнэлж нэг удаа улируулан томилж болно.

4.6.Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрх томилогдсон өдрөөс эхэлж, хууль, энэ журамд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн өдрөөс эхлэн дуусгавар болно.

4.7.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч дараах үндэслэлээр төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг чөлөөлөх, эсхүл бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох саналыг гаргана:

4.7.1.энэ журмын 3.1, 3.2, 3.3-т заасан шаардлага хангахгүй болох нь нотлогдсон;

4.7.2.төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 3 ба түүнээс дээш удаа оролцоогүй;

4.7.3.хууль, энэ журам болон компанийн дүрэмд заасан үүргээ зохих ёсоор үнэнч шударгаар гүйцэтгээгүй, эсхүл ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр удаа дараа хангалтгүй үнэлэгдсэн, компанийг зохистой удирдах шаардлагыг хангахгүй болсон;

4.7.4.эрхэлсэн ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн;

4.7.5.хууль, энэ журам болон компанийн дүрмийг зөрчсөн аливаа үйлдэл, эс үйлдэл хийсэн;

4.7.6.гэмт хэрэг үйлдсэнийг шүүхээс тогтоож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

4.7.7.хууль, энэ журам болон компанийн дүрэмд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашигласан, олж авсан мэдээлэл, бизнесийн нууц, компанийн хөрөнгийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашигласан;

4.7.8.эрх бүхий байгууллагаас тухайн албан тушаалыг эрхлэхтэй холбоотой мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, эрхийг хүчингүй болгосон;

4.7.9.үүргээ гүйцэтгэх боломжгүй болох нөхцөл байдал бий болсон, өөрөө чөлөөлөгдөх хүсэлт гаргасан.

4.8.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн энэ журмын 4.7.3, 4.7.4, 4.7.5, 4.7.6-д заасан үйлдлийн улмаас компанид учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

Тав.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах

5.1.Энэ журмын 4.1-д заасан төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн шийдвэрээр байгуулсан Ажлын хэсэг хариуцан зохион байгуулах бөгөөд Ажлын хэсэгт хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч, холбогдох төрийн захиргааны төв байгууллага, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын болон бусад шаардлагатай төлөөллийг оролцуулна.

5.2.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь холбогдох асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс санал авч, нэр дэвшүүлж ирүүлсэн төлөөллийг тухайн төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтад оролцуулна.

5.3.Ажлын хэсэг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд тавих нийтлэг болон тусгай шаардлага, сонгон шалгаруулалтад оролцогчийн бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг тодорхойлж, энэ журмын 5.2-т заасны дагуу санал авахад хавсарган хүргүүлнэ.

5.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг баримт бичгийн бүрдэл шалгах, нийтлэг болон тусгай шаардлагыг үнэлэх, ярилцлага хийх гэсэн үе шаттайгаар зохион байгуулж, нэр дэвшигчийг дараах байдлаар үнэлж, сонгон шалгаруулна:

5.4.1.сонгон шалгаруулалтад оролцогчийн баримт бичгийн бүрдэл, нийтлэг болон тусгай шаардлагад нийцэж байгаа эсэхийг тус тус үнэлж, үнэлгээний онооны нийлбэр дүнгээр нь эрэмбэлж, хамгийн өндөр оноо авсан 5 хүртэлх нэр дэвшигчийг ярилцлагын шатанд оруулах;

5.4.2.ярилцлагын үнэлгээг нийт нийлбэр дүнтэй нэгтгэн эрэмбэлж, хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилуулахаар хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид санал болгож хүргүүлэх.

5.5.Сонгон шалгаруулалтын үе шат, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, нэр дэвшигч тус бүрийн үнэлгээний оноог хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, тухайн компанийн цахим хуудаст нээлттэй, ил тод байршуулна.

5.6.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд сонгон шалгаруулж санал болгосон нэр дэвшигчийг хууль, энэ журамд заасан шаардлага хангаагүй үндэслэлээр томилохоос татгалзсан тохиолдолд дараагийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг санал болгох, эсхүл сонгон шалгаруулалтыг дахин зохион байгуулна.

Зургаа.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний эрх, үүрэг

6.1.Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4, 6 дахь хэсэгт зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

6.1.1.хууль, компанийн дүрэмд заасан эрх, үүргээ үнэнч шударгаар, зөвхөн компанийн ашиг сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэх;

6.1.2.хувьцаа эзэмшигчдийн болон төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд оролцож, шийдвэр гаргахад санал өгөх;

6.1.3.шийдвэр гаргахад шаардагдах бүх мэдээлэлтэй танилцах, бүрэн мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах;

6.1.4.албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглах, компанийн талаарх мэдээ, мэдээлэл, бизнесийн нууц, хөрөнгийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;

6.1.5.өөрөө, эсхүл түүний хамаарал бүхий этгээд дангаараа, эсхүл хамтран компанийн хувьцаа эзэмшигч болсон даруйд мэдэгдэх.

6.2.Төрийн өмчит компанийн үйл ажиллагааны онцлогтой уялдуулан төрийн өмчийн төлөөлөгчийн эрх, үүргийг тухайн компанийн дүрмээр тусгайлан тогтоож болно.

6.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь ажлын гүйцэтгэл, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг жил бүр хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлнэ.

6.4.Энэ журамд заасны дагуу төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэхээр томилогдсон төрийн захиргааны албан хаагч 2-оос илүү төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлд орж ажиллахыг хориглоно.

Долоо.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин хөлс

7.1.Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин хөлсний хэмжээг тухайн компанийн үйл ажиллагааны чиглэл, онцлог, цар хүрээ, нийт актив хөрөнгийн хэмжээ, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан тогтоох бөгөөд цалин хөлсийг цагаар тооцож олгоно.

7.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үндсэн цалингийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг, эсхүл тухайн салбарын болон салбар дундын хамтын хэлэлцээрээр тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлснээс ихгүй байх бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороонд ажилласан байдлыг харгалзан нэмэгдэл олгож болно. Нэмэгдлийн хэмжээ үндсэн цалингийн хэмжээний дөрөвний нэгээс хэтрэхгүй байна.

7.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин хөлсийг цагаар тооцож олгох аргачлалыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

7.4.Энэ журмын 7.3-т заасан аргачлалыг баримтлан төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин хөлсийг тухайн компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч, төрийн өмчийн оролцоотой компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин хөлсийг тухайн компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал тус тус батална.

7.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн хууль, энэ журам болон компанийн дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол цалин хөлс олгохыг зогсоох, эсхүл үүргээ биелүүлээгүй хугацаанд нь хамаарах хувь хэмжээгээр цалин хөлсний хэмжээг бууруулна.

7.6.Энэ журмын 7.5-д заасны дагуу цалин хөлс олгохыг зогсоох, эсхүл бууруулах асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлийн даргын саналыг үндэслэн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч шийдвэрлэнэ.

7.7.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн энэ журамд заасан цалин хөлснөөс бусад баталгаа, хангамж эдлэхийг хориглоно.

7.8.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдөхөд нөхөн төлбөр, олговор зэрэг аливаа хэлбэрийн тэтгэмж олгохыг хориглоно.

Найм.Хариуцлага

8.1.Энэ журмын 2.1.1, 2.1.3-т заасан этгээд албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлсэн

шийдвэр гаргуулахаар оролдох, нөлөөлөх аливаа үйлдэл гаргасан тохиолдолд гүйцэтгэх удирдлага хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид мэдэгдэнэ.

8.2.Хууль, энэ журамд нийцсэн удирдамж, чиглэлийг зөрчсөн буюу зохих ёсоор биелүүлээгүй, энэ журмын 8.1-д заасан үйлдлийг гаргасан нь тогтоогдсон тохиолдолд төрийн өмчийн төлөөлөгчийн бүрэн эрхийг дуусгавар болгоно.

8.3.Эрх бүхий этгээдээс баталсан удирдамжийн дагуу гарсан хувьцаа эзэмшигчдийн хурлын болон төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээс үүсэх үр дагаврыг энэ журмын 2.1.1, 2.1.3-т заасан этгээд хариуцахгүй.

8.4.Эрх бүхий этгээдээс баталсан удирдамж, чиглэлийг зөрчсөн, эсхүл тухайн асуудлаар удирдамж, чиглэл авахгүйгээр хувьцаа эзэмшигчдийн болон төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцож, шийдвэр гаргасны улмаас учирсан хохирлыг тухайн буруутай этгээд хариуцан арилгана.

Ес.Бусад зүйл

9.1.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч энэ журмын 2.1.1, 2.1.3-т заасан этгээдийг томилсон мэдээллийг тухай бүр, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний ажлын гүйцэтгэлийг үнэлсэн тайлан, мэдээллийг жил бүр төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тус тус хүргүүлнэ.

9.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг явуулж дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор сонгон шалгаруулалтын үйл ажиллагааны тайланг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухай бүр хүргүүлнэ.

9.3.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Санхүүгийн зохицуулах хорооноос эрх олгосон сургалтын байгууллагатай хамтран ахисан шатны сургалт явуулж, төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын мэдлэг, чадварыг дээшлүүлэх ажлыг тогтмол зохион байгуулна.

9.4.Төрийн өмчит компани нь хууль, энэ журамд нийцүүлэн тухайн компанийн дүрэмд төрийн төлөөллийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар зохицуулалт оруулж, үйл ажиллагаандаа мөрдөж болно.

ХАВСРАЛТ2

Английн компанийн хууль (Companies act 2006)-д заасан нөлөө бүхий этгээдийн хүлээх үүрэг:

Компанийн захирал нь:
(а) Компанийн үндсэн хуульд нийцүүлэн үйл ажиллагаа явуулах,
(б) Өөрт олгогдсон эрхүүдийг зөвхөн тухайн эрхүүд олгогдсон зорилгоор хэрэгжүүлэх үүрэгтэй.

172. Компаний ашигтай байдлыг тэргүүнд тавих үүрэг

(1) Компанийн захирал нь сайн санаагаар, компанийн амжилттай ажиллахын тулд хамгийн сайн арга замыг хэрэгжүүлэх хэрэгтэй. Үүнийг хийхдээ дараах зүйлсийг харгалзан үзнэ:

(а)Компаниудын ёс зүйн бизнесийн стандартыг хангах,

(б)Компанийн гишүүдийн хооронд шударга байдалтай үйл ажиллагаа явуулах шаардлагатай.

(2) Хэрэв компанийн зорилго нь зөвхөн гишүүдийн ашиг тусыг хуулиар заасан бол, уг үүрэг нь компанийн бусад зорилгод нийцүүлэн ажиллах ёстой.

(3) Энэ хэсгийн дагуу компанийн захирлууд үүргээ гүйцэтгэхдээ, зарим тохиолдолд компанийн хөндлөнгийн талуудын (кредитор) ашиг сонирхлыг харгалзан үзэх шаардлага гарч болно.

Энэ үүргийн зорилго нь компанийн нийт гишүүдийн ашиг сонирхлыг хамгаалах бөгөөд захирлууд ямар нэг шийдвэр гаргахдаа олон хүчин зүйлсийг харгалзан үзэх ёстой. Үүнд:

- Урт хугацаанд ямар үр дагавар гарах,
- Компаний ажилтнуудын ашиг сонирхол,
- Компаний нийлүүлэгчид, хэрэглэгчидтэй бизнесийн харилцааг дэмжих,
- Нийгэм болон хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөө,
- Компаний өндөр нэр хүндийг хадгалах хэрэгцээ зэрэг зүйлсийг авч үзнэ.

173. Хараат бус шийдвэр гаргах үүрэг

(1) Компанийн захирал нь бие даан шийдвэр гаргах ёстой.

(2) Энэ үүргийг зөрчихгүйгээр захирал нь дараах нөхцөлд ажиллах боломжтой:

(а) Компанийн гаргасан зөвшөөрлөөр захирлуудын ирээдүйн шийдвэр гаргах эрхийг хязгаарласан гэрээг дагаж ажиллах, эсвэл

(б) Компанийн үндсэн хуульд зөвшөөрөгдсөн байдлаар ажиллах.

174. Анхааралтай, чадварлаг, хичээнгүй ажиллах үүрэг

(1) Компанийн захирал нь зөвхөн анхааралтай, чадварлаг, хичээнгүйгээр ажиллах ёстой.

(2) Энэ нь анхааралтай, чадвар, хичээнгүй байдлыг илэрхийлнэ, энэ нь:

- (a) Компанийн захирлын үүргийг гүйцэтгэж байгаа хүнээс ихэвчлэн хүлээгдэж болох ерөнхий мэдлэг, ур чадвар, туршлага,
(b) Захирлын өөрийн эзэмшсэн ерөнхий мэдлэг, ур чадвар, туршлага.
-

175. Ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх үүрэг

(1) Компанийн захирал нь өөртөө, эсвэл өөрийн сонирхолд зөрчилтэй буюу зөрчилдөж болзошгүй ашиг сонирхолтой байдалд орсон эсвэл орж болох нөхцөл байдлыг зайлсхийх ёстой.

(2) Энэ нь ялангуяа компанийн эд хөрөнгө, мэдээлэл эсвэл боломжийг ашиглахад хамаарна (компани эд хөрөнгө, мэдээлэл эсвэл боломжийг ашиглаж чадах эсэх нь ач холбогдолгүй).

(3) Энэ үүрэг нь компанитай хийсэн гүйлгээ эсвэл тохиролцоотой холбоотой ашиг сонирхлын зөрчилд хамаарахгүй.

(4) Энэ үүргийг зөрчсөн гэж тооцогдохгүй—

(a) Хэрвээ нөхцөл байдал нь ашиг сонирхлын зөрчил үүсгэх магадлалтай гэж бодогдохгүй бол, эсвэл

(b) Хэрвээ асуудал нь захирлуудын зөвшөөрснөөр шийдэгдсэн бол.

(5) Захирлууд зөвшөөрөл олгох боломжтой—

(a) Хэрвээ компани нь хувийн компани бөгөөд компанийн үндсэн хуульд ийм зөвшөөрөл олгохыг хориглосон зүйлгүй бол, асуудлыг захирлуудын өмнө оруулж, зөвшөөрөл олгосноор; эсвэл

(b) Хэрвээ компани нь олон нийтийн компани бөгөөд түүний үндсэн хуульд захирлууд асуудлыг зөвшөөрөх эрхтэй байх заалт орсон бол, асуудлыг захирлуудын өмнө оруулж, үндсэн хуульд нийцүүлэн зөвшөөрөл олгох замаар.

(6) Зөвшөөрөл зөвхөн дараах нөхцлүүдийг хангасан бол хүчинтэй болно—

(a) Асуудалтай холбогдох хуралдаанд шаардлагатай ирц хангагдсан байх ёстой бөгөөд асуудал дээр санал өгөөгүй захирал эсвэл бусад сонирхолтой захирлуудыг тооцохгүй,

(b) Асуудал зөвшөөрөгдсөн байх ёстой бөгөөд захирлуудын санал өгөхгүй бол ч зөвшөөрөгдсөн байх ёстой.

(7) Энэ бүлэгт ашиг сонирхлын зөрчил гэдэгт ашиг сонирхол болон үүргийн зөрчил, эсвэл үүргийн зөрчил багтана.

176. Гуравдагч этгээдээс ашиг авахгүй байх үүрэг

(1) Компанийн захирал нь гуравдагч этгээдээс дараах шалтгааны улмаас ашиг авах ёсгүй:

(a) Тэрээр захирал байгаагаар, эсвэл

(b) Тэрээр захирлаар хийсэн (эсвэл хийгээгүй) үйлдлээр.

(2) “Гуравдагч этгээд” гэдэг нь компаниас өөр хүн, холбогдсон байгууллага эсвэл компанийн эсвэл холбогдсон байгууллагын төлөөлөгчийг хэлнэ.

(3) Захирлын компанид үзүүлсэн үйлчилгээ (захирлын үүрэг гүйцэтгэх эсвэл бусад үүрэг) нь гуравдагч этгээдээс өгсөн ашиг гэж тооцогдохгүй.

- (4) Хэрвээ ашиг авах нь ашиг сонирхлын зөрчил үүсгэх магадлалтай биш гэж бодогдох бол энэ үүрэг зөрчигдсөн гэж тооцогдохгүй.
- (5) Энэ хэсэгт ашиг сонирхлын зөрчил гэдэгт ашиг сонирхол болон үүргийн зөрчил, эсвэл үүргийн зөрчил багтана.
-

177. Тохиролцоо эсвэл гэрээтэй холбоотой үүсч буй байдалд сонирхлын зөрчил үүсвэл мэдэгдэл өгөх үүрэг

- (1) Хэрвээ компанийн захирал нь ямар нэгэн байдлаар, шууд эсвэл дам байдлаар компанитай хийх гэж буй тохиролцоо эсвэл гэрээнд сонирхолтой бол, тэрээр энэ сонирхол болон түүний хэмжээтэй байдалд мэдэгдэл өгөх ёстой.
- (2) Мэдэгдэл дараах байдлаар хийгдэж болно (гэхдээ заавал биш):
- (a) Захирлуудын хуралдаанд, эсвэл
- (b) Захирлуудад мэдэгдэл өгнө—
- (i) 184-р зүйлд заасан (бичгээр мэдэгдэл), эсвэл
- (ii) 185-р зүйлд заасан (ерөнхий мэдэгдэл).
- (3) Хэрэв энэ мэдэгдэл нь буруу эсвэл дутагдалтай байгааг илрүүлсэн бол, дахин мэдэгдэл хийх ёстой.
- (4) Энэ мэдэгдлийг компанийн тохиролцоо эсвэл гэрээ хийхээс өмнө хийх ёстой.
- (5) Хэрэв захирал нь мэдээгүй байгаа эсвэл тухайн тохиролцоо эсвэл гэрээг мэдэхгүй байгаа тохиолдолд мэдэгдэл өгөх шаардлагагүй. Энэ зориулалтаар захирал нь өөрөө мэдэж байх ёстой зүйлсийг мэдэж байгаа гэж тооцогдоно.
- (6) Захирал сонирхолтой байдалд мэдэгдэл өгөх шаардлагагүй—
- (a) Хэрвээ энэ нь ашиг сонирхлын зөрчил үүсгэх магадлалтай биш гэж бодогдох;
- (b) Хэрвээ бусад захирлууд үүнийг аль хэдийн мэддэг бол (мөн бусад захирлууд нь өөрсдөө мэдэж байх ёстой зүйлсийг мэдэж байгаа гэж тооцогдоно); эсвэл
- (c) Хэрвээ энэ нь захирлын үйлчилгээний гэрээний нөхцлүүдтэй холбоотой бөгөөд эдгээр нөхцлүүдийг захирлуудын хуралдаан эсвэл компанийн үндсэн хуульд заасан захирлуудын бүлэгт хэлэлцүүлнэ.
-

ХАВСРАЛТЗ

Австралийн компанийн хууль (Corporations act 2001)-д заасан нөлөө бүхий этгээдийн хүлээх үүрэг:

Section 180 - Duty of Care and Diligence (Анхаарал, хичээл зүтгэлтэйгээр үйл ажиллагаа явуулах үүрэг)

Захирлууд нь өөрсдийн хариуцлагатай байдалд, боломжит хүмүүсийн хувьд тэнцүү анхаарал, хичээл зүтгэлтэйгээр үйл ажиллагаа явуулах ёстой.

Section 181 - Duty to Act in Good Faith (Сайн дурын үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулах үүрэг)

Захирлууд нь компанийн бүх нийтийн ашиг сонирхолыг хангах үүднээс сайн дураар, шударгаар үйл ажиллагаа явуулах ёстой.

Section 182 - Duty Not to Misuse Position (Байр сууриа буруугаар ашиглахгүй байх үүрэг)

Захирлууд нь өөрсдийн байр сууриа хувийн ашиг сонирхлоор эсвэл хэн нэгэнд давуу эрх олгох зорилгоор, эсвэл компанид хохирол учруулах зорилгоор ашиглахгүй байх ёстой.

Section 183 - Duty Not to Misuse Information (Мэдээллийг буруугаар ашиглахгүй байх үүрэг)

Захирлууд нь өөрсдийн байр сууриа ашиглан олж авсан мэдээллийг хувийн ашиг сонирхлоор эсвэл компанид хохирол учруулах зорилгоор ашиглахгүй байх ёстой.

Section 184 - Duty to Avoid Reckless or Intentional Misconduct (Анхааралгүй эсвэл санаатай буруутай үйлдлээс зайлсхийх үүрэг)

Захирлууд нь компанид эсвэл түүний гишүүдэд хохирол учруулж болзошгүй анхааралгүй эсвэл санаатай буруутай үйлдлүүдээс зайлсхийх ёстой.

Section 190 - Related Party Transactions (Хамааралтай талуудын гүйлгээ хийх үүрэг)

Захирлууд нь хамааралтай талуудтай хийж байгаа гүйлгээг компанийн ашиг сонирхолд нийцсэн, шударга бөгөөд зохистой байхыг хангах ёстой.

